



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ



**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ,
ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ
АЖЛЫН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2021 он**

ГАРЧИГ

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ	2-3
1.1. Хяналтын шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлан	4-6
1.1.1. Эрүүгийн хэргийн танхим	7-15
1.1.2. Иргэний хэргийн танхим	16-23
1.1.3. Захиргааны хэргийн танхим	24-33
1.2. Шүүн таслах ажиллагаанаас бусад ажлын талаар	34
1.2.1. Нийт шүүгчийн хуралдаан	34-36
1.2.2. Шүүгчдийн зөвлөгөөн	36-40
ХОЁР.ТАМГЫН ГАЗАР	41
2.1. Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах чиглэлээр	42-46
2.1.1. Шүүгчийн хараат бус байдал	46-48
2.1.2. Хүний нөөц, сургалт	48-51
2.1.3. Архив, номын сан	51-55
2.1.4. Цагаатгалын бүртгэл	56-57
2.1.5. Техник, программ хангамж	57
2.2. Шүүхийн зохион байгуулалтын чиглэлээр	58-60
2.3. Шүүхийн практик судалгааны чиглэлээр	60-69
2.4. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиглэлээр	70-74
2.5. Шүүхийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр	75-80
2.6. Шүүхийн төсөв, санхүү, нийтлэг үйлчилгээний чиглэлээр	80-85
ГУРАВ.ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН	86
3.1. Шүүхийн сургалтын талаар	87
3.2. Шүүхийн судалгааны талаар	88
3.3. Мэдээллийн талаар	88-89



НЭГ.МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн...

(Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгээс)

ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно” гэж заасан.

Монгол Улсын Их хурлаас 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын шүүхийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг баталж, 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс даган мөрдөж эхлэв.


Монгол Улсын шүүхийн тухай хуульд Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг шүүн таслах ажиллагааны талаарх болон шүүн таслах ажиллагаанаас бусад асуудлаарх бүрэн эрх гэж хуульчилан заасан байна.

Мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 24.1-д заасны дагуу Монгол Улсын дээд шүүхийн дэргэд Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнг Ерөнхий шүүгчийн 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 35 дугаар захирамжаар үүсгэн байгуулсан билээ.


Монгол Улсын дээд шүүхийн 2021 оны тайлан нь бүтцийн хувьд Монгол Улсын дээд шүүхийн, түүний Тамгын газрын, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн гэсэн гурван хэсгээс бүрдэх ба хуульд заасан бүрэн эрх, чиг үүргээр ангилж, хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээг оруулсан бөгөөд Тамгын газрын тайланд 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тусгасан болно.

1.1. ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


Улсын дээд шүүх 2021 онд нийт 4165 хэрэг хүлээн авсан бөгөөд танхимуудад дараах байдлаар хуваарилагдсан байна:



Шүүх хуралдаанаар 2116 хэрэг хянан шийдвэрлэсэн бөгөөд тэдгээрийг танхимуудаар нь харуулбал:




Улсын дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимуудын 2021 онд хүлээж авсан хэргийг өмнөх онтой харьцуулбал:





2021 онд шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэргийг өмнөх онтой харьцуулбал:



Хяналтын шатны шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимуудын сүүлийн 10 жилд хүлээн авч шийдвэрлэсэн хэргийн тоон мэдээг тус бүрээр харуулбал:







1.1.1.ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ

Эрүүгийн хэргийн танхим 2020 оны үлдэгдэл **70** хэрэг дээр 2021 онд хяналтын журмаар эрүүгийн **788**, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах прокурорын дүгнэлттэй **5**, цагаатгалын **28** хэрэг буюу нийт **891** хэргийг хүлээн авч;

Тайлант хугацаанд шүүгчийн захирамжаар **140** хэргийг, танхимын нийт шүүгчийн хуралдаанаар **389** хэргийг нийт **529** хэргийн гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, **322** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд одоогоор **40** хяналтын хэргийн үлдэгдэлтэй байна.




Эрүүгийн хэргийн танхим **322** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэхдээ нийт **53** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **6** хэрэг, танхимын нийт шүүгчийн хуралдаанаар **475** /389 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, 86 хэргийг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн/ хэргийн гомдол болон холбогдох шүүхийн шийдвэрүүдийг хэлэлцэхдээ **28** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **17** хэргийг тус тус хянан хэлэлцжээ.

Хяналтын журмаар шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн **322** хэргийн **42.5** хувь буюу **137** хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, **27** хувь буюу **87** хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, **30.5** хувь буюу **98** хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгожээ.

Өөрчлөлт оруулсан **87** хэргийн **71.2** хувь буюу **62** хэргийг Эрүүгийн хууль буруу тайлбарлан хэрэглэсэн, **3.5** хувь буюу **3** хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн үндэслэлээр өөрчлөлт тус тус оруулж, **25.3** хувь буюу **22** хэргийн зүйлчлэл өөрчлөлгүйгээр ялыг хөнгөрүүлжээ.

Хүчингүй болгосон **98** хэргийн **20.4** хувь буюу **20** хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, **25.5** хувь буюу **25** хэргийн шийтгэх, цагаатгах тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгож (үүнээс **24** хувь буюу **6** хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгасан), **23.4** хувь буюу **23** хэргийг нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцааж, **26.5** хувь буюу **26** хэргийн магадлалыг хүчингүй болгож, шийтгэх, цагаатгах тогтоолыг хэвээр үлдээж, **4.1** хувь буюу **4** хэргийн шийтгэх, цагаатгах тогтоолын зарим заалтыг хүчингүй болгожээ.

Тайлант хугацаанд Танхимын тэргүүн Ч.Хосбаяр **67**, шүүгч Б.Амарбаясгалан **79**, С.Батдэлгэр **76**, Б.Батцэрэн **77**, Б.Цогт **49**, Д.Эрдэнэбалсүрэн **85**, С.Соёмбо-Эрдэнэ **49**, танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэх **20** /Эрүүгийн хэргийн танхим/ хэргийг тус тус хүлээн авчээ.



Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Ч.Хосбаяр **267**, шүүгч Б.Амарбаясгалан **281**, Д.Эрдэнэбалсүрэн **285**, Б.Цогт **274**,

С.Батдэлгэр **270**, Б.Батцэрэн **271**, С.Соёмбо-Эрдэнэ **98** удаа тус тус оролцсоноос;

Танхимын тэргүүн Ч.Хосбаяр **50**, шүүгч Б.Цогт **140**, Б.Амарбаясгалан **63**, С.Батдэлгэр **45**, Б.Батцэрэн **34**, Д.Эрдэнэбалсүрэн **24**, С.Соёмбо-Эрдэнэ **6** удаа шүүх хуралдааныг даргалж;

Танхимын тэргүүн Ч.Хосбаяр **47**, шүүгч Б.Амарбаясгалан **62**, С.Батдэлгэр **56**, Б.Батцэрэн **62**, Б.Цогт **45**, Д.Эрдэнэбалсүрэн **62**, С.Соёмбо-Эрдэнэ **28** эрүүгийн хэрэг илтгэсэн байна.



Эрүүгийн хэргийн танхим нийт **48** өргөдөл гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Ч.Хосбаяр **18**, шүүгч Б.Амарбаясгалан **2**, Б.Батцэрэн **8**, С.Батдэлгэр **3**, Б.Цогт **7**, Д.Эрдэнэбалсүрэн **10** өргөдөл гомдол,

мөн **188** албан бичиг хүлээн авснаас Танхимын тэргүүн Ч.Хосбаяр **94**, Б.Амарбаясгалан **9**, Б.Батцэрэн **12**, С.Батдэлгэр **16**, Б.Цогт **39**, Д.Эрдэнэбалсүрэн **15**, С.Соёмбо-Эрдэнэ **3** албан бичиг тус тус хянан шийдвэрлэжээ.

Улсын дээд шүүх 2021 онд прокурорын дүгнэлт бичиж ирүүлсэн нийт **28** цагаатгалын хэргийг хүлээн авч, үүнээс 18 хэлмэгдэгчид холбогдох **16** хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж, **2** хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, **3** хэргийн прокурорын дүгнэлтийг хүлээн авахаас татгалзаж, **1** хэрэгт прокурор дүгнэлтээ буцаан авч, ажиллагаанд **6** хэргийн үлдэгдэлтэй байна.

Хэлмэгдэгчдийн төрөл садангаас цагаатгуулах хүсэлт **5**, нөхөн олговор олгох хүсэлт **10** тус тус ирүүлснийг харьяаллын дагуу зохих байгууллагуудад шилжүүлсэн.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **322** хэргийн **24.5** хувь буюу **79** хэргийг шүүгдэгчийн, **2.5** хувь буюу **8** хэргийг хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгчийн, **47.8** хувь буюу **154** хэргийг өмгөөлөгчийн, **0.6** хувь буюу **2** хэргийг иргэний хариуцагчийн, **16.8** хувь буюу **54** хэргийг улсын яллагчийн эсэргүүцлээр, **7.8** хувь буюу **25** хэргийг прокурорын дүгнэлтээр хэлэлцжээ.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний захирамж **356** гарснаас шүүхийн харьяалал тогтоох тухай **19**, хэрэг хянан шийдвэрлэх хугацаа сунгах тухай **12**, шүүгч томилон ажиллуулах тухай **164**, хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхгүй тухай **7**, шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүн томилсон шийдвэрийг албажуулах тухай бүрэлдэхүүн томилох тухай **154** захирамж гарчээ.

Танхимын тэргүүн Ч.Хосбаяр **24**, шүүгч С.Соёмбо-Эрдэнэ **24**, Б.Батцэрэн **23**, Д.Эрдэнэбалсүрэн **22**, Б.Амарбаясгалан **21**, С.Батдэлгэр **20**, Б.Цогт **6** нийт **140** хэргийг хянаж шүүгчийн захирамжаар буцаасан байна.

Мөн энэ хугацаанд эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны тогтоол **475**, танхимын зөвлөгөөний тогтоол **71**, шүүхийн тогтоол **90**, мэдэгдэх хуудас **119** гарсан байна.

Улсын дээд шүүхийн хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн **2** хэргийн **50** хувь буюу **1** хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол, шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй болгож, **50** хувь буюу **1** хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолыг хүчингүй болгожээ.

Улсын дээд шүүхийн хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэсэн **1** хэргийг шүүгдэгчийн өмгөөлөгч, **1** хэргийг хохирогчийн гомдлоор хэлэлцжээ.

Шүүн таслах ажиллагаанаас бусад ажлын талаар:

- Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, С.Батдэлгэр, Б.Батцэрэн, Б.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн нар нь нийслэл, орон нутгийн шүүгч нарт Эрүүгийн хуульд орсон нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор ерөнхий ангийн хэм

хэмжээ, зарим төрлийн гэмт хэргийг шийдвэрлэхэд анхаарах асуудлын талаарх сургалтыг онлайн хэлбэрээр “Ханс-Зайделын сан”-тай хамтран явуулсан.

- Шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлал, журмын төсөл боловсруулах ажлын хэсэгт Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Д.Эрдэнэбалсүрэн нар,

- Улсын Дээд шүүхэд ирсэн хэрэг нэхэмжлэл, гомдол хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг маргааныг шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журам боловсруулах ажлын хэсэгт Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Б.Батцэрэн нар,

- Эрүүгийн хэргийн танхимын нэр бүхий шүүгч нар Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн байнгын ажлын хэсгийн гишүүнээр,

- 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Олон Улсын Эрүүгийн шүүхийн бүс нутгийн уулзалтад Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Д.Эрдэнэбалсүрэн нар оролцсон.

- Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Б.Батцэрэн нар нь 2021 оны 12 дугаар сард “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа” сэдвээр сургалтын контент бэлтгэх ажилд оролцсон.

- Мөн Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Б.Батцэрэн нар нь Монгол Улсын нэгдэн орсон “Хүнийг хүчээр алга болгохын эсрэг конвенци”-ын тайлан хамгаалах ажлын хэсэгт томилогдон 2021 оны 04 дүгээр сарын 21-нээс 23-ны өдрүүдэд оролцож ажилласан.

- Шүүгч Б.Батцэрэн, Б.Цогт нар нь 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдөр “Өршөөл үзүүлэх тухай хууль”-ийг нэг мөр ойлгож, хэрэглэх талаар нийслэл, орон нутгийн нийт шүүгч нартай онлайн уулзалт зохион байгуулж, холбогдох мэдээлэл өгсөн байна.

Танхимын тэргүүн Ч.Хосбаяр:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулагдсан “Хүний эрхийн үндэсний чуулган-2021” арга хэмжээний үндсэн хуралдаанд “Хүний эрх ба шүүх эрх мэдэл” илтгэл тавьж хэлэлцүүлсэн.

- Авлигатай тэмцэх газраас 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан “Авлигын эсрэг форум-2021” арга хэмжээнд “Авлигын хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлсэн.

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан болон үр дагаврын асуудал хариуцсан НҮБ-ын Тусгай илтгэгч Рем Алсалемтай 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдөр уулзалтад оролцсон.

- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, Улсын Их хуралд өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсэгт орж хамтран ажиллаж байна.

Шүүгч Б.Батцэрэн:

- 2021 оны 6 дугаар сард “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр шүүгч, прокурорт зориулсан гарын авлагыг бусад зохиогч нар болон Азийн сантай хамтран боловсруулсан. Уг гарын авлагад Монголын хуульчдын холбоо магадлан итгэмжлэл олгосон.

- Өршөөл үзүүлэх тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцэн батлахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын хэсэгт ХЗБХ-ны даргын тогтоолоор томилогдон ажилласан бөгөөд уг хууль 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан.

- 2021 оны 9 дүгээр сарын 11-нээс 12-ны өдрүүдэд Хуульчийн сонгон шалгаруулалтын “Эрүүгийн эрх зүйн бодлого үнэлэх комисс”-ыг ахалж ажилласан.

- 2021 онд Нотариатчийн мэргэжлийн хорооны гишүүнээр сонгогдож, 2021 оны 10 дугаар сарын 25-наас 31-ний өдрүүдэд “Нотариатчийн мэргэшлийн шалгалт”-ыг зохион байгуулахад оролцсон.

- 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч нарт “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр багц цаг олгох сургалтыг онлайн хэлбэрээр явуулсан.

- 2021 оны 02 дугаар сарын 25-нд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцсон.

- Узбекистан улсын Ташкент хотноо зохион байгуулагдсан Эрүүгийн шударга ёсны асуудлаарх Төв Азийн улс орнуудын эрүүгийн эрх зүйн мэргэжилтнүүдийн найм дахь удаагийн уулзалтад 2021 оны 11 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд оролцсон.

Шүүгч Б.Амарбаясгалан:

- Монгол Улсын дээд шүүхийн 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 07 дугаар Ерөнхий шүүгчийн захирамжаар Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн бүтэц, орон тоо, ажиллах журам, шүүгчийн сургалтын хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг ахалж ажилласан.

- Монгол Банкны дэд ерөнхийлөгч бөгөөд хамтын ажиллагааны зөвлөлийн даргын 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр баталсан Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүнээр ажлын хэсэгт орж ажилласан.

- Санхүүгийн мэдээллийн албаны дэргэдэх хамтын ажиллагааны зөвлөлийн ажлын хэсгийн гишүүнээр шүүгч Б.Амарбаясгалан оролцсон.

- Монголын хуульчдын холбооноос зохион байгуулсан Хуульчийн сонгон шалгаруулалтад 2021 оны 09 дүгээр сарын 11-12, 17-ны өдрүүдэд Эрүүгийн эрх зүйн бодлого дүгнэх комиссын гишүүнээр ажилласан.

- Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирлын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/87 тоот тушаалаар 2021 оны мэргэжлийн магистрын хэлэлцүүлгийг дүгнэх ажлын хэсэгт орж ажилласан.

Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн:

- 2021 оны “Шүүхийн сонгомол шийдвэр шалгаруулах” ажлын хэсгийн гишүүнээр,

- Монгол Банкны Санхүүгийн мэдээллийн албаны дэргэдэх хамтын ажиллагааны зөвлөлийн ажлын хэсгийн гишүүнээр,

- Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн тухай мэдээлэл авсан бол цагдаагийн байгууллага энэ байдлыг

таслан зогсооход чиглэсэн арга хэмжээ авах журам"-ыг боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр,

- Нийт шүүгчийн чуулганы ажлын хэсгийн, мөн нийт шүүгчийн чуулганы дэгийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр,

- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенци болон түүний нэмэлт протоколуудын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын тайланг боловсруулах, бусад улсын тайланг хянаж, санал дүгнэлт боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр тус тус оролцсон.

- Нийт шүүгчийн чуулганы зорилго, ач холбогдол болон зохион байгуулалтын арга хэмжээний талаар “Өдрийн сонин”-д 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдөр ярилцлага өгсөн.

- Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн магистрын ангиудад 2021 оны 11, 12 дугаар саруудад нийт 12 цагийн хичээл заасан.

- 2021 оны 05 дугаар сарын 25-наас 26-ны хооронд зохион байгуулагдсан “Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх” талаарх олон улсын сургалтад онлайнаар суралцсан.

- Нээлттэй нийгэм форумаас зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийлэл, Хүний эрхийн талаарх” сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон.

- Эрүүгийн хэргийн танхимаас Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар “Өршөөл үзүүлэх тухай хуулийн зарим зүйл, хэсгийг тайлбарлах” болон нэр бүхий иргэнд холбогдох хэргийн харьяалал тогтоолгохтой холбоотой асуудлыг тус тус хэлэлцүүлсэн.



1.1.2. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ


Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл 5 хэрэг, нэмж хяналтын шатны журмаар 2648, харьяалал тогтоолгохоор 13, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар 37, нийт 2703 хэрэг хүлээн авч, 1576 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 36 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар хэлэлцэж, 87 хэргийг гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзах болон гомдол гаргаагүйд тооцож, 913 хэргийг танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж, 13 хэрэг, 3 хүсэлтэд шүүхийн харьяаллыг тогтоож, одоо хуваарилагдсан нийт 116 /хяналтын журмаар хүлээн авсан 114, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт 2/ хэргийн үлдэгдэлтэй байна.

Түүнчлэн Шүүхийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө хяналтын гомдол гаргаж ирсэн, шүүгчид хуваарилагдаагүй иргэний хэрэг тайлангийн эцсийн байдлаар 965 хэргийн үлдэгдэлтэй байна.

2021 оны 3 дугаар сарын 01-нээс хойш Иргэний хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаан 24 өдөр хуралдаж, нийт 913 хэрэг хүлээн авснаас 49 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр, 864 хэргийг хяналтын журмаар хэлэлцүүлэхээс татгалзаж, хүлээн авсан 49 хэргийн 38 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн байна.

/Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар 913 хэрэг хэлэлцсэнээс гомдлыг хүлээн авч хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн 38 хэрэг давхардаж байгаа тул хасч 875 хэрэг болсон болно./

Нийт хүлээн авсан 2703 хэргээс



Иргэний хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаанаар нийт **90** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **27** хэрэг хэлэлцжээ.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн иргэний **1576** хэргийн **58.1** хувь буюу **916** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **8.4** хувь буюу **132** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж, **22.6** хувь буюу **356** хэргийн шийдвэр, магадлалд нэмэлт, өөрчлөлт оруулж, **7.4** хувь буюу **116** хэргийн магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилж, **3.5** хувь буюу **56** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна.

Өөрчлөлт оруулсан **356** шийдвэр, магадлалын **60.1** хувь буюу **214** нь хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, **39.9** хувь буюу **142** нь шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулжээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийн дахин хэлэлцүүлэхээр буцаасан **132** хэргийн **12.1** хувь буюу **16** хэргийг шүүгч гарын үсэг зураагүй үндэслэлээр давж заалдах шатны шүүхрүү буцаасан, **50** хувь буюу **66** хэргийг шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй гэж, **32.6** хувь буюу **43** хэргийг шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн, **5.3** хувь буюу **7** хэргийг хэргийг оролцогчийн эрхийг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ.


Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон **56** хэргийн **39.3** хувь буюу **22** нь зохигчийн эвлэрлийг баталсан, **60.7** хувь буюу **34** нь шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай **38** хэргийн **36** хэргийг тайлангийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд **34** хүсэлтийг хангаагүй, **2** хүсэлтийг хангаж, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг ердийн журмаар шийдвэрлүүлэхээр буцаасан байна.

Хяналтын журмаар танхимын тэргүүн Г.Алтанчимэг **152**, шүүгч Л.Атарцэцэг **40**, Г.Банзрагч **130**, П.Золзаяа **233**, Б.Мөнхтуяа **116**, С.Соёмбо-Эрдэнэ **154**,

Х.Сонинбаяр **190**, Б.Ундрах **149**, Г.Цагаанцоож **171**, Д.Цолмон **232**, Х.Эрдэнэсүвд **210** хэрэг тус тус хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Г.Алтанчимэг **562**, шүүгч Л.Атарцэцэг **129**, Г.Банзрагч **344**, П.Золзаяа **631**, Б.Мөнхтуяа **225**, С.Соёмбо-Эрдэнэ **369**, Х.Сонинбаяр **527**, Б.Ундрах **410**, Г.Цагаанцоож **543**, Д.Цолмон **578**, Х.Эрдэнэсүвд **605** удаа **оролцсоноос**;

Танхимын тэргүүн Г.Алтанчимэг **135**, шүүгч Л.Атарцэцэг **33** Г.Банзрагч **105**, П.Золзаяа **194**, Б.Мөнхтуяа **96**, С.Соёмбо-Эрдэнэ **125**, Х.Сонинбаяр **317**, Б.Ундрах **169**, Г.Цагаанцоож **157**, Д.Цолмон **153**, Х.Эрдэнэсүвд **157** хуралдааныг тус тус **даргалж**;

Танхимын тэргүүн Г.Алтанчимэг **150**, шүүгч Л.Атарцэцэг **26**, Г.Банзрагч **113**, П.Золзаяа **219**, Б.Мөнхтуяа **102**, С.Соёмбо-Эрдэнэ **145**, Х.Сонинбаяр **176**, Б.Ундрах **135**, Г.Цагаанцоож **170**, Д.Цолмон **208**, Х.Эрдэнэсүвд **197** хэргийг **илтгэсэн** байна.

Иргэний хэргийн танхимын шүүгчдийн 2021 оны бүтэн жилийн ажлын ачаалал



Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **41.4** хувь буюу **653** нэхэмжлэгчийн, **53.6** хувь буюу **845** хариуцагчийн, **3.1** хувь буюу **49** зохигчийн, **1.8** хувь буюу **29** гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **1576** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

Иргэний хуулиар **904**, Хөдөлмөрийн тухай хуулиар **247**, Гэр бүлийн тухай хуулиар **97**, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар **272**, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар **17**, бусад хуулиар **39** хэргийг хянан шийдвэрлэжээ.

Мөн энэ хугацаанд зохигч этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт **1 144 114 890** /нэг тэр бум нэг зуун дөчин дөрвөн сая нэг зуун арван дөрвөн мянга найман зуун ер/ төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний **640 966 077** /зургаан зуун дөчин сая есөн зуун жаран зургаан мянга далан долоо/ төгрөгийг буцаан олгожээ.

Тус танхим 2021 онд иргэнд, хуулийн этгээдээс нийт **69** албан бичиг, **76** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Г.Алтанчимэг **27** албан бичиг, **44** өргөдөл, гомдол, шүүгч Л.Атарцэцэг **1** албан бичиг, **1** өргөдөл, гомдол, Г.Банзрагч **2** албан бичиг, **2** өргөдөл, гомдол, П.Золзаяа **2** албан бичиг, **3** өргөдөл, гомдол, Б.Мөнхтуяа **2** албан бичиг, **2** өргөдөл, гомдол, С.Соёмбо-Эрдэнэ **2** албан бичиг, **1** өргөдөл, гомдол, Х.Сонинбаяр **16** албан бичиг, **17** өргөдөл, гомдол, Б.Ундрах **2** албан бичиг, **1** өргөдөл, гомдол, Г.Цагаанцоож **7** албан бичиг, **1** өргөдөл, гомдол, Д.Цолмон **3** албан бичиг, **1** өргөдөл гомдол, Х.Эрдэнэсүвд **5** албан бичиг, **2** өргөдөл, гомдол тус тус хянан шийдвэрлэж, одоо **1** өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **2100** гаргаснаас Танхимын тэргүүний “Шүүх бүрэлдэхүүн томилох тухай” **1685**, харьяалал тогтоосон **1**, “Улсын тэмдэгтийн хураамж буцааж олгох тухай” **327**, “Гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” **6**, “Гомдол гаргаагүйд тооцох тухай” **81** шүүгчийн захирамж,

Шүүхийн тогтоол **274** гарснаас “шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлт шийдвэрлэсэн” **36**, шүүгчийг татгалзан гарах хүсэлт шийдвэрлэсэн **13**, шүүх хуралдаан хойшлуулсан **59**, хүсэлт хэрэгсэхгүй болгосон **166** тогтоол тус тус гарчээ.

Иргэний хэргийн танхим 2021 оны байдлаар Улс төрийн намын бүртгэлийн талаар дараах ажлыг хийжээ. Үүнд:

- Зон олны намын намын даргын өөрчлөлт бүртгүүлэх тухай хүсэлтийг 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр хэлэлцэж 01 дүгээр тогтоолоор хангаж;
- Ардчилсан намын үндсэн дүрмийн нэмэлт өөрчлөлт бүртгүүлэх тухай хүсэлтийг 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр хэлэлцэж 04 дүгээр тогтоолоор хангахаас татгалзаж;
- Иргэний Зориг Ногоон намын даргын өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлтийг 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр хэлэлцэж 05 дугаар тогтоолоор хангахаас татгалзаж;
- Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын даргын өөрчлөлт бүртгүүлэх тухай хүсэлтийг 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр хэлэлцэж 06 дугаар тогтоолоор хангахаас татгалзаж;
- Хөдөлмөрийн үндэсний намын даргын өөрчлөлт бүртгүүлэх тухай хүсэлтийг 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр хэлэлцэж 07 дугаар тогтоолоор хангаж;
- Ардчилсан намын Цахим мэдээллийн санд Ардчилсан намын даргаар С.Эрдэнийг дахин байршуулж, тэмдэглэлийг сэргээлгэх тухай хүсэлт, Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг Улсын бүртгэлд бүртгүүлэх тухай хүсэлтийг 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр хэлэлцэж 06 дугаар тогтоолоор хангахаас татгалзаж;
- Иргэний хэргийн танхимаас Ард түмнээ хайрлая намын даргын өөрчлөлт бүртгүүлэх тухай, Иргэний Зориг Ногоон намын хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлтийг тус тус Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанд оруулж, 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.
- Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам батлагдаж, улс төрийн намын бүртгэлийг Захиргааны хэргийн танхим хариуцах болсонтой холбоотойгоор Тамгын газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, Иргэний хэргийн танхимд хадгалагдаж байсан улсын бүртгэлд бүртгэлтэй 36 нам, бүртгэхээс татгалзсан 13 намын хувийн хэрэг болон холбогдох баримтуудыг эмхлэн цэгцэлж нийт 112 хавтас, 22654 хуудас баримтыг шинээр дугаарлан үдэж хавтаслан Захиргааны хэргийн танхимд хүлээлгэн өгч, акт үйлдсэн.

Иргэний хэргийн танхимын шүүгчид:

Монгол улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөнтэй холбоотойгоор Иргэний

хэргийн танхимын 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар “Танхимын нийт шүүгчийн хуралдааны дэг болон зохион байгуулах журмыг баталсан.

Түүнчлэн Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг: “Улсын дээд шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт, хүлээн авах, хуваарилах, шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүн томилох журам боловсруулах” ажлын хэсэг 2 удаа орж, журмын төслийг боловсруулан, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан,

Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, шүүгч Г.Банзрагч, П.Золзаяа нар “Шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлал, журмын төсөл боловсруулах” ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж аргачлал журмын төслийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэх батлуулсан;

Шүүгч П.Золзаяа: 2021 оны “Иргэний сургалтын гарын авлага боловсруулах” ажлын хэсгийн гишүүнээр;

Шүүгч Д.Цолмон: “Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн бүтэц, орон тоо, ажиллах журам, шүүгчийн сургалтын хөтөлбөрийн төсөл боловсруулах” ажлын хэсгийн гишүүнээр;

Шүүгч Х.Эрдэнэсүвд: “Улсын дээд шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний болон Нийт шүүгчийн хуралдааны дэгийн төсөл боловсруулах” ажлын хэсгийн гишүүнээр;

Шүүгч Б.Ундрах, Х.Эрдэнэсүвд нар “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын төсөл боловсруулах” ажлын гишүүнээр;

Шүүгч Г.Цагаанцоож: “Улсын дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоолуудад судалгаа хийсэн:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын алба хаагчдын үндэсний чуулган”-д шүүгч Х.Эрдэнэсүвд, С.Соёмбо-Эрдэнэ, Д.Цолмон нар оролцож, танхимын тэргүүн Г.Алтанчимэг “Шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдал ба хуулийн засаглал” салбар хуралдаанд илтгэл тавьж оролцсон

Иргэний хэргийн танхимын шүүгчид багш шүүгч нарын хамт Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс зохион байгуулсан “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим” сэдэвт 3 өдрийн сургалтад 2021.11.30-2021.12.03-ны өдрүүдэд суусан;

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд заасны дагуу Шүүгчдийн чуулганд танхимын шүүгчид оролцож, шүүгч Г.Банзрагч чуулганыг даргалж, шүүгч

Г.Цагаанцоож Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр, шүүгч Б.Ундрах Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр тус тус сонгогдсон;

Иргэний шүүгч нарын сургалтад зориулж танхимын тэргүүн Г.Алтанчимэг “нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл” шүүгч Г.Банзрагч “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 97.1, 97.2, 170.1, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг яаж хэрэглэх талаар”, шүүгч П.Золзаяа “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74, 106 дугаар зүйлийг хэрэглэхэд анхаарах асуудал”, шүүгч Д.Цолмон “Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх онцлог, анхаарах асуудал”, шүүгч Х.Эрдэнэсүвд “Улсын тэмдэгтийн хураамж хуваарилах талаар” судалгаа хийж, сургалтыг зохион байгуулсан;

Шүүгч Г.Банзрагч: Хуульчдын холбооны Сургалтын хорооны хуралд 3 удаа оролцож, Монголын үндэсний телевизийн “Монгол Улсын нэрийн өмнөөс” дугаарт оролцож, ярилцлага өгч, Монголын шүүгчдийн холбооноос зохион байгуулж буй “Ярьдаг хууль” телевизийн цуврал нэвтрүүлэгт оролцож, Захиргааны ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлтийг боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байна.

Шүүгч П.Золзаяа: 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Хууль зүйн дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан “Хувийн эрх зүйн шинэтгэлийн явц, тулгамдаж буй асуудал сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний хуралд “Хувийн эрх зүйн шинэтгэл ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр илтгэл тавьж, танхимын тэргүүн Г.Алтанчимэг тус хуралдаанд оролцсон;

Иргэний хэргийн танхимаас “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3, 106.5 дахь заалтад хуулийн албан ёсны тайлбар гаргуулах” асуудлыг Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэн, хуулийн тайлбар гаргахаар ажиллаж байна.




1.1.3.ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

Захиргааны хэргийн танхим **2020** оны үлдэгдэл **34** хэрэг дээр **2021** онд Хяналтын шатны журмаар **447** хэрэг, Давж заалдах шатны журмаар **8**, Шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар **15**, Шүүхийн ёс зүйн хорооны **9**, Мэргэжлийн хариуцлагын хорооны **1**, нийт **514** хэргийг хүлээн авч, **145** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар, **15** хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцох эсэхийг хэлэлцэж, **22** хэргийн гомдлыг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжид гомдол гаргасныг хянан хэлэлцэж, танхимын нийт шүүгчийн хуралдаанаас **292** хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзсан болон буцаасан, хуралдаанд оролцуулахгүйгээр **25** хэргийг шийдвэрлэж, одоо **15** хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан захиргааны 514 хэргээс



2021 оны 3 дугаар сарын 01-нээс хойш Захиргааны хэргийн танхим **332** хэргийг хүлээн авч танхимын нийт шүүгчийн хуралдааныг **21** өдөр зохион байгуулан хуралдаж, **39** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэж, **281** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, **11** хэргийн гомдлыг (итгэмжлэлийн хугацаа дууссан **4**, гомдол гаргах хугацаа хэтрүүлсэн **5**, улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй **2**)

буцааж, **1** хэргийн гомдлыг хэлэлцэх шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүйн улмаас хойшлогдсон байна.

Захиргааны хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт **32** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **5.7** хэрэг хэлэлцжээ.

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн **145** хэргийн **60** хувь буюу **87** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **9.7** хувь буюу **14** хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, **30.3** хувь буюу **44** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгожээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон **44** хэргийн **43.2** хувь буюу **19** хэргийн магадлалыг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөлт оруулж, **25** хувь буюу **11** хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах шатны шүүхэд буцааж, **31.8** хувь буюу **14** хэргийн нэхэмжлэлийг болон хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн байна.

Шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан **14** хэргийн **21.4** хувь буюу **3** хэргийг шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **42.8** хувь буюу **6** хэргийн шийдвэр, магадлалыг бусад, **35.7** хувь буюу **5** хэргийг хууль буруу хэрэглэсэн үндэслэлээр тус тус өөрчлөлт оруулжээ.


Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлттэй **17** хэргийн **12** хүсэлтийг хангахгүй орхиж, **3** хэргийн хүсэлтийг хангаж, **1** хэргийн оролцогч хүсэлтээсээ татгалзаж, **1** хэргийн оролцогчийн хүсэлтийг буцаасан байна.

Шүүгч нарын хүлээн авсан хэргийн тоо зөрүүтэй байгаа нь шүүгч Б.Мөнхтуяа /УДШ-ийн Тамгын газрын даргын 2021-02-05-ны өдрийн Б/16 тушаалаар 2021.02.05-наас 2021.03.05-ны өдөр/ хүртэл 1 сарын чөлөө авсан тул түүнд хуваарилагдсан өмнөх оны үлдэгдэл болон шинээр хүлээн авсан 10 хэргийг шүүгч нарт шилжүүлэн хуваарилсан. Үүнд: шүүгч Г.Банзрагч 2, Х.Батсүрэн 2, М.Батсуурь 2, Д.Мөнхтуяа 1, П.Соёл-Эрдэнэ 1, Ц.Цогт 2 хэрэг, мөн Монгол Улсын дээд шүүхийн нийтийн шүүгчийн хуралдааны 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн “Танхимын бүрэлдэхүүн батлах тухай” 07 дугаар тогтоол гарч шүүгч Б.Мөнхтуяа, Г.Банзрагч нар 2021.04.26-ны өдрөөс Иргэний хэргийн танхимд шилжсэнтэй холбогдуулан эдгээр шүүгчид хуваарилагдсан байсан 4 хэргийг авч, танхимын шүүгч нарт шилжүүлэн хуваарилсан. Тодруулбал: шүүгч Г.Банзрагчаас шүүгч Ц.Цогт 1, П.Соёл-Эрдэнэ 1 (ШИНБ хүсэлттэй), шүүгч Б.Мөнхтуяагаас шүүгч Х.Батсүрэн 1 (ШИНБ хүсэлттэй), П.Соёл-Эрдэнэ 1 хэргийг шилжүүлсэн, түүнчлэн шүүгч Ц.Цогт УДШ-ийн ерөнхий шүүгчийн

2021.06.17-ны өдрийн 26 дугаар захирамжаар 2021.05.18-наас 2021.06.16-ны өдрүүдэд чөлөөтэй, Танхимын тэргүүн Ч.Тунгалаг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн зөвлөгөөний 2021 оны 09 дүгээр тогтоолын дагуу 1 өнжиж хэрэг авч байсантай холбоотой.

Хяналтын журмаар шүүгч М.Батсуурь **37**, Х.Батсүрэн **37**, П.Соёл-Эрдэнэ **30**, Ц.Цогт **30**, Д.Мөнхтуяа **33**, Г.Банзрагч **25**, Б.Мөнхтуяа **14**, Ч.Тунгалаг **4** захиргааны хэрэг тус тус хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг:




Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд шүүгч П.Соёл-Эрдэнэ **91**, Д.Мөнхтуяа **84**, Х.Батсүрэн **82**, М.Батсуурь **76**, Ц.Цогт **56**, Г.Банзрагч **39**, Ч.Тунгалаг **33**, Б.Мөнхтуяа **26** удаа оролцсоноос;

Танхимын тэргүүн Ч.Тунгалаг **97**, шүүгч Х.Батсүрэн **18**, М.Батсуурь **10**, Д.Мөнхтуяа **10**, Ц.Цогт **9**, П.Соёл-Эрдэнэ **10**, Б.Мөнхтуяа **9**, Г.Банзрагч **3** хэргийн шүүх хуралдааныг даргалж;

Шүүгч Х.Батсүрэн **29**, М.Батсуурь **28**, Г.Банзрагч **21**, Д.Мөнхтуяа **24**, П.Соёл-Эрдэнэ **22**, Ц.Цогт **23**, Б.Мөнхтуяа **12**, Ч.Тунгалаг **3** хэрэг илтгэсэн байна.

Захиргааны хэргийн танхимын шүүгчдийн 2021 оны ажлын ачаалал:



Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлт хэлэлцэх шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Ч.Тунгалаг **14**, шүүгч М.Батсуурь **14**, Х.Батсүрэн **13**, П.Соёл-Эрдэнэ **13**, Д.Мөнхтуяа **11**, Ц.Цогт **7**, Г.Банзрагч **2**, Б.Мөнхтуяа **1** удаа оролцсоноос:

Танхимын тэргүүн Ч.Тунгалаг **5**, шүүгч Д.Мөнхтуяа **4**, Х.Батсүрэн **2**, П.Соёл-Эрдэнэ **2**, М.Батсуурь **1**, Ц.Цогт **1** удаа даргалж;

Шүүгч Х.Батсүрэн **5**, М.Батсуурь **4**, П.Соёл-Эрдэнэ **3**, Ц.Цогт **2**, Д.Мөнхтуяа **1** хэрэгт гаргасан хүсэлтийг илтгэсэн байна.

Гомдлыг хүлээн авахаас татгалзсан захирамж хэлэлцэх шүүх хуралдаанд шүүгч М.Батсуурь **16**, Г.Банзрагч **13**, Д.Мөнхтуяа **13**, Х.Батсүрэн **10**, Б.Мөнхтуяа **7**, П.Соёл-Эрдэнэ **8**, Ц.Цогт **5**, Ч.Тунгалаг **4** удаа оролцсоноос;

Шүүгч М.Батсуурь **5**, Д.Мөнхтуяа **5**, Г.Банзрагч **4**, Ч.Тунгалаг **3**, Х.Батсүрэн **2**, П.Соёл-Эрдэнэ **2**, Ц.Цогт **2**, Б.Мөнхтуяа **1** хэргийн шүүх хуралдааныг **даргалж**;

Шүүгч Г.Банзрагч **5**, М.Батсуурь **5**, Д.Мөнхтуяа **4**, Х.Батсүрэн **3**, П.Соёл-Эрдэнэ **3**, Б.Мөнхтуяа **2**, Ц.Цогт **2** хэрэгт гаргасан гомдлыг **илтгэсэн** байна.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **145** хэргийн **42.1** хувь буюу **61** итгэмжлэгдсэн төлөөлөгчийн, **17.2** хувь буюу **25** нэхэмжлэгчийн, **23.4** хувь буюу **34** өмгөөлөгчийн, **10.3** хувь буюу **15** хариуцагчийн, **7** хувь буюу **10** гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцжээ.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **145** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл: газрын маргаан **29**, ашигт малтмалын маргаан **21**, төрийн албаны маргаан **15**, төрийн болон орон нутгийн өмчийн тухай маргаан **14**, татварын маргаан **14**, эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой маргаан **4**, сонгуулийн маргаан **2**, мэргэжлийн хариуцлагын хорооны **1**, бусад **45** хэргийг тус тус хянан шийдвэрлэжээ.

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт **25,131,600** /хорин таван сая нэг зуун нэг мянга зургаан зуун/ төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний **16,637,400** /арван зургаан сая зургаан зуун гучин долоон мянга дөрвөн зуун/ төгрөгийг буцаан олгожээ.

Захиргааны хэргийн танхим нь **39** өргөдөл, гомдол, албан бичиг (Танхимын тэргүүн Ч.Тунгалаг **4** албан бичиг, **2** өргөдөл, шүүгч Х.Батсүрэн **3** албан бичиг, **2** өргөдөл, М.Батсуурь **2** албан бичиг, **3** өргөдөл, Д.Мөнхтуяа **2** албан бичиг, **4** өргөдөл, П.Соёл-Эрдэнэ **2** албан бичиг, **6** өргөдөл, Г.Банзрагч **2** албан бичиг, **1** өргөдөл, Ц.Цогт **1** албан бичиг, **3** өргөдөл, Б.Мөнхтуяа **1** өргөдөл)

хүлээн авч, танхимын нийт шүүгчийн хуралдаанд танилцуулж, **38** албан бичиг, өргөдөлд хариу өгч, одоо **1** албан бичгийн үлдэгдэлтэй байна.

2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн өмнө хүчин төгөлдөр мөрдөж байсан ЗХШХШТХ-ийн 128.4 дэх заалтын дагуу хоёр шүүгч тусгай санал гаргаж, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанд шүүгч Х.Батсүрэн 1 хэрэг илтгэн, хянан хэлэлцүүлсэн.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-д заасны дагуу Захиргааны хэргийн танхим намын бүртгэлтэй холбоотой өргөдлийг хүлээн авах болсон. Тус танхимд нийт **21** өргөдөл хүлээн авснаас Танхимын тэргүүн Ч.Тунгалаг **3**, шүүгч Х.Батсүрэн **1**, П.Соёл-Эрдэнэ **1**, Ц.Цогт **1** өргөдлийг буцааж, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанд Танхимын тэргүүн Ч.Тунгалаг **1**, шүүгч Х.Батсүрэн **2**, М.Батсуурь **2**, Д.Мөнхтуяа **3**, П.Соёл-Эрдэнэ **2**, Ц.Цогт **1** өргөдлийг илтгэж, одоо **4** өргөдлийн үлдэгдэлтэй байна.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанд шүүгч Х.Батсүрэн **1**, Д.Мөнхтуяа **1** хэргийн харьяалал тогтоолгох хүсэлтийг тус тус илтгэн шийдвэрлүүлсэн байна.

Тайлангийн хугацаанд **237** шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол гаргаснаас “Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолтой хэрэгт бүрэлдэхүүн томилох тухай” Танхимын тэргүүний захирамж **11**, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай” **83** захирамж, “шүүх хуралдааныг хойшлуулах тухай” **68** тогтоол, захирамж, “гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай” **22** шүүгчийн захирамж, “гомдол хүлээн авахаас татгалзсан захирамжийг хянасан” **22** шүүхийн тогтоол, “улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай” **9** захирамж, “шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шийдвэрлэх тухай” **15** шүүхийн тогтоол, “гомдол гаргаагүйд тооцох тухай” **3** захирамж, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан **2**, шүүгчээс татгалзсан хүсэлтийг шийдвэрлэсэн **2** тогтоол, захирамж гаргажээ.

Ажлын хэсэг

Танхимын тэргүүн Ч.Тунгалаг Шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал, журмын төсөл боловсруулах ажлын хэсгийн ахлагч;

Танхимын тэргүүн Ч.Тунгалаг, шүүгч Ц.Цогт нар Улсын дээд шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах, шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүн томилох журмыг боловсруулах ажлын хэсгийн гишүүн;

Шүүгч Г.Банзрагч Шүүхийн шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүн;

Шүүгч Г.Банзрагч, Ц.Цогт нар нь ХЗДХСайдын байгуулсан Захиргааны ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийн гишүүн;

Шүүхийн судалгааны төв /сектор/-ийн ажиллах журмын төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүн;

Шүүгч М.Батсуурь Улсын төрийн намын бүртгэл хөтлөх журмын төсөл боловсруулах ажлын хэсгийн ахлагч;

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн бүтэц, орон тоо, ажиллах журам, шүүгчийн сургалтын хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүн;

Улс төрийн нам тараахтай холбоотой хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүн;

Шүүгч Д.Мөнхтуяа Монгол Улсын шүүхийн тухай хуулийн (шинэчилсэн найруулга) ажлын хэсгийн гишүүн;

Нийт шүүгчдийн чуулганыг зохион байгуулалтын ажлын хэсгийн ахлагч;

“Монгол Улсын эрх зүйн шинэтгэл хөтөлбөр-2” төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүн;

Шүүгч П.Соёл-Эрдэнэ Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны болон шүүгчдийн зөвлөгөөний дэг боловсруулах ажлын хэсгийн гишүүн;

Нотариатчдын танхимын дэргэдэх Сахилгын зөвлөлийн гишүүн;

Шүүгч Ц.Цогт Монгол Улсын шүүхийн тухай хуулийг УИХ-аар хэлэлцүүлэхэд бэлтгэх Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх Дэд ажлын хэсгийн гишүүн;

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5 дахь заалтын хэрэгжилтийг судалж, санал гаргах үүрэг бүхий хэсгийн гишүүнээр тус тус ажилласан.

Хурал, уулзалт, ярилцлага

Танхимын тэргүүн Ч.Тунгалаг: Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн албаны Монгол

Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг ажиглах түр хорооны хуулийн шинжээч Рената Тардиолиг 2021 оны 6 дугаар сарын 04-ний өдөр хүлээн авч уулзсан;

Шүүгч Г.Банзрагч: 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Сонгуулийн хуулийн талаар Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллагын төлөөлөгч нартай цахим уулзалт хийсэн;

2021 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын шүүхийн тухай хуулийн зарим зохицуулалт, нийт шүүгчийн чуулганы талаар “Монгол Улсын нэрийн өмнөөс” Монголын Үндэсний Радио, телевизийн нэвтрүүлэгт оролцсон;

Монголын Хуульчдын холбооны Сургалтын хорооны хуралд 3 удаа оролцсон;

Шүүгч М.Батсуурь: 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Хуульчдын форумд оролцсон;

Шүүгч Д.Мөнхтуяа: Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, нийт шүүгчийн хуралдааны зохион байгуулах ажлын хэсгүүдэд орж ажилласантай холбогдуулан тухай бүр товлогдсон хурал болон уулзалт, Байнгын хорооны дэд ажлын хэсгийн хуралд оролцож ажилласан;

Дээрх ажлын хэсгүүдэд орж ажилласантай холбогдуулан тухай бүр товлогдсон ажлын хэсгийн 18 удаагийн хурал, Байнгын хорооны дэд ажлын хэсгийн хуралд оролцсон;

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/-аас 2021 оны 04 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулсан “Шүүгч эмэгтэйчүүдийн холбоо” сэдэвт ОУ-ын цахим хуралд оролцож, илтгэл тавьсан;

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын алба хаагчдын үндэсний чуулган” 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан “Шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдал ба хуулийн засаглал” салбар хэлэлцүүлэгт модератороор оролцсон;

МУИС-ийн Хууль зүйн сургууль, Япон Улсын Нагояагийн их сургуулийн Хуулийн факультет, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Нагояагийн Их сургуулийн Азийн Сателит Кампус Институт, Монгол Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Ханнс Зайделийн сан, Азийн сан, Монголын Хуульчдын холбоо, Чимид сан, Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан legaldata.mn 2021 оны 11 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд хамтран зохион байгуулсан “Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн

үндсэн асуудлууд” ОУ-ын эрдэм шинжилгээний хурлын “Fundamental issues of administrative law” салбар хуралдаанд “Judicial Review of Government Decisions in Mongolia: Practice and Some Analysis” сэдвээр илтгэл тавьж оролцсон;

МҮОНТ-ийн “Монгол Улсын нэрийн өмнөөс” нэвтрүүлэгт 2021 оны 3 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улсын шүүхийн тухай хуулийн талаар,

“Eagle” телевизийн “Зочны цаг” нэвтрүүлэгт 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдөр “Нийт шүүгчийн чуулган”-ы талаар,

МҮОНТ-ийн “ММ агентлаг”-ийн “Онцлох зочин”-оор 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдөр “Нийт шүүгчийн чуулган”-ы талаар тус тус оролцож, ярилцлага өгсөн.

Шүүгч П.Соёл-Эрдэнэ: 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Төрийн албаны нууцын тухай мэдлэг олгох тухай” сэдэвт сургалт;

2021 оны 11 дүгээр сарын 20, 21-ний өдрүүдэд Монгол Улсын Үндсэн хуулийн эрхийг баригч Б.Чимидийн нэрэмжит “Үндсэн хуулийн болон Захиргааны эрх зүйн үндсэн асуудлууд: хямралын үеийн тулгамдсан асуудал” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний 3 дахь хуралд;

2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 10 дугаар сарын 22-ны өдөр Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ILO/ ОУХБ)-аас Монголын Хуульчдын холбоотой хамтран зохион байгуулсан “Олон Улсын Хөдөлмөрийн хэм хэмжээний тухай Хууль зүйн боловсролыг үргэлжлүүлэх нь” сэдэвт сургалтад тус тус оролцсон.

Шүүгч Ц.Цогт: 2021 оны 11 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд болсон “Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн үндсэн асуудлууд” хямралын үеийн тулгамдсан асуудал олон улсын эрдэм шинжилгээний хуралд “Fundamental issues of Administrative law” салбар хуралдаанд “Statutory Interpretation in Administrative Law: Introducing Judicial Precedent” сэдвээр;

2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр болсон Хүний эрхийн үндэсний форум 2021-д “Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог боловсронгуй болгох нь” салбар хуралдаанд Хүний эрхийг сэргээн эдлүүлэх тогтолцоо үр нөлөөтэй байх шалгуурын үүднээс “Шүүн таслах ажиллагааны шатлал-чиг үүрэг, шүүхийн тогтолцоо, шүүх бүрэлдэхүүн, шийдвэрийн биелэлтийг авч үзэх нь сэдвээр тус тус илтгэл тавьсан.

Бусад асуудлаар.

Танхимын тэргүүн Ч.Тунгалаг, шүүгч М.Батсуурь, Ц.Цогт нар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулагдсаны 10 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний шилдэг өгүүллийн уралдааныг дүгнэсэн;

Шүүгч Г.Банзрагч: Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын байцаагч нарт “Захиргааны актын эрх зүйн зохицуулалт” сэдвээр сургалтын хөтөлбөр боловсруулж, 2 удаа сургалт зохион байгуулсан;

Шүүгч М.Батсуурь: Улсын төрийн намын бүртгэл хөтлөх журам, түүний хавсралтыг;

Улс төрийн нам тараах, бүртгэлээс хасах журмын төслийг тус тус боловсруулсан.

Шүүгч Д.Мөнхтуяа: “Нийт шүүгчийн анхдугаар чуулган зохион байгуулах ажлын хэсгийн ажиллах журам”, Нийт шүүгчийн чуулганы хуралдааны дэг, “Хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам”-уудын төслийг боловсруулахад оролцсон;

Нийт шүүгчийн чуулганыг зохион байгуулах төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүнд нэр дэвших, сонгох үйл ажиллагаа, санал хураалт зэрэг ажлуудыг зохион байгуулсан.

Шүүгч П.Соёл-Эрдэнэ: 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Нийт шүүгчдийн чуулганд тооллогын комиссын гишүүнээр ажилласан.

Шүүгч Ц.Цогт: Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааныг зохион байгуулах дэгийн төсөл, Хяналтын журмаар хэлэлцүүлэх хэрэг хүлээн авсан шүүгч судалгаа хийлгэх асуудал, түүний хүрээг тодорхойлсон танилцуулга бэлтгэж, бүрэлдэхүүнд танилцуулах, Судалгааны хүрээлэнд захиалга хүргүүлэх загварын төсөл боловсруулсан.


АНУ-ын Duke University School of Law –д Шүүх судлалын мастерын хөтөлбөрт 2021 оноос эхлэн суралцаж байгаа (5, 6 дугаар сард цахимаар)

МУИС Хууль зүйн сургуульд 6.5 кредит хичээл зааж байгаа.

1.2. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНААС БУСАД АЖЛЫН ТАЛААР

2021 онд Монгол Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдаан 11 удаа хуралдаж, давхардсан тоогоор 40 асуудал хэлэлцэж, 38 тогтоол баталжээ. Шүүгчдийн зөвлөгөөн 7 удаа хуралдаж, 11 асуудал хэлэлцэж, 11 тогтоол баталсан байна.

2016-2021 онд буюу сүүлийн 5 жилд Монгол Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдаан 18 удаа, Шүүгчдийн зөвлөгөөн 22 удаа хуралдсан байна.



1.2.1. Нийт шүүгчийн хуралдаанаар 2021 онд хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлууд

1. 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдөр

- 1.1. “Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны дэгийн төсөл”-ийг хэлэлцэн батлав.
- 1.2. “Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгох тухай” асуудлыг хэлэлцэж, Ж.Эрдэнэбулганыг Улсын Их Хуралд санал болгосон.
- 1.3. “Эрүүгийн хэргийн танхимын саналаар Монгол Улсын шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 15 дугаар зүйлийг тайлбарлах тухай Улсын дээд шүүхийн тогтоолын төсөл хэлэлцэн батлах тухай” асуудлыг хэлэлцсэн.

2. 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр

- 2.1. “Танхимын бүрэлдэхүүн батлах тухай” асуудлыг хэлэлцэж, Улсын дээд шүүхийн Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхимын бүрэлдэхүүнийг батлав.
- 2.2. “Хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох тухай” асуудлыг шийдвэрлэв.
- 2.3. “Улс төрийн намын бүртгэл хөтлөх тухай журам” баталсан.

3. 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр

- 3.1. Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны дэгт нэмэлт, өөрчлөлт оруулсан.
- 3.2. “Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх тухай” Ардчилсан намын, Ард Түмнээ Хайрлая намын, Иргэний Зориг Ногоон намын хүсэлтийг тус тус хэлэлцэн шийдвэрлэв.
- 3.3. “Улс төрийн намын бүртгэл хөтлөхтэй холбоотой зарим асуудлын тухай” хэлэлцэж, ажлын хэсэг байгуулсан.

4. 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр

- 4.1. “Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх тухай” Ардчилсан намын, Монгол Ардын намын хүсэлтийг тус тус хэлэлцэв.
- 4.2. “Хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох тухай” асуудлыг хэлэлцэж хэргийн харьяаллыг Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд тогтоосон.
- 4.3. “Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгох тухай” асуудлыг хэлэлцсэн.
- 4.4. “Улсын дээд шүүхээс бусад шүүхийн байршлыг тогтоох, шүүх байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах тухай” Ерөнхий зөвлөлийн саналыг танилцуулсан.

5. 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

- 5.1. “Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх тухай” Монгол Ардын Хувьсгалт намын хүсэлтийг хэлэлцсэн.

6. 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдөр

- 6.1. Ардын чуулган нам үүсгэн байгуулсныг бүртгүүлэх тухай иргэн Ш.Сайхансамбуугийн хүсэлтийг хэлэлцсэн.
- 6.2. “Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгох тухай” асуудлыг хэлэлцсэн.

7. 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

- 7.1. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх тухай Монгол ардын нам /МАН/-ын хүсэлтийг хэлэлцэх тухай.

8. 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр

- 8.1. Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны дэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.
- 8.2. “Ардын чуулган” нам үүсгэн байгуулсныг бүртгүүлэх тухай иргэн Ш.Сайхансамбуугийн өргөдлийг хэлэлцэх тухай.
- 8.3. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгох.

8.4.Шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлал, журмын төсөл хэлэлцэн батлах.

9. 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдөр

9.1.Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх тухай Ардчилсан намын хүсэлтийг хэлэлцэх тухай.

9.2.Иргэний хэргийн танхимын саналаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах эсэхийг шийдвэрлэх тухай.

10. 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр

10.1.Өршөөл үзүүлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргуулах тухай санал.

10.2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсгийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргуулах тухай санал.

10.3.Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалтын талаар албан ёсны тайлбар гаргуулах тухай санал.

10.4.Тогтоолд өөрчлөлт оруулах эсэхийг хэлэлцэх тухай.

11. 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

11.1.Өршөөл үзүүлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах тухай.

11.2.Р.Сүхбаатарт холбогдох шинэ нөхцөл байдал тогтоолгох тухай прокурорын дүгнэлттэй хэргийн харьяаллыг тогтоох тухай.

11.3.“Иргэдийн оролцооны нэгдэл нам” /ИОНН/ шинээр үүсгэн байгуулсныг бүртгүүлэх тухай иргэн Ц.Оюунгэрэлийн өргөдлийг хэлэлцэх тухай.

11.4.Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт бүртгүүлэх тухай Ардчилсан намын хүсэлт.

11.5. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгох.

1.2.2.Шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлууд

Улсын дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөн нийт 7 удаа товлон зарлагдаж, 11 асуудал хэлэлцэж, 13 цаг хуралдсан байна.

1.2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр

1.1.“Улсын дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний дэгийн төсөл”-ийг батлав.

1.2.“Улсын дээд шүүхэд ирсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилох түр журам”-ын төслийг баталсан.

1.3.“Танхим /Захиргаа, Иргэн, Эрүү/-ын тэргүүнийг сонгох тухай” асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

2.2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр.

2.1.“Улсын дээд шүүхэд ирсэн хэрэг маргаан, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах, шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүн томилох түр журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

2.2.Шүүгчид чөлөө олгох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

3. 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдөр

3.1.Ерөнхий зөвлөл, сахилгын хорооны гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэх.

4.2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

4.1.Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирлыг томилох асуудал танилцуулах.

5. 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр

5.1. Зарим хүмүүсийг шагналд тодорхойлох тухай.

6. 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр

6.1.“Улсын дээд шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол хүсэлт хүлээн авах, хуваарилах болон шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журам” батлах тухай.

7. 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

7.1.Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирлыг томилох асуудал танилцуулах.

7.2. Шагналд тодорхойлох тухай.

Монгол Улсын шүүхийн тухай хууль (шинэчилсэн найруулга) 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөнтэй холбогдуулан Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдааны дэг болон Үндсэн хуулиас бусад хуулийн албан ёсны тайлбар гаргах асуудлуудыг хэлэлцэж баталсан бөгөөд Нийт шүүгчийн хуралдааны дэгт нийт 3 удаа нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна.

Мөн Нийт шүүгчийн 5 удаагийн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилуулахаар олонхийн санал авсан Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар нарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэрийг нь дэвшүүлж, Монгол Улсын Их Хуралд санал болгосон.

Монгол Улсын дээд шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний дэгийг шинэчлэн баталж, Улсын дээд шүүхэд ирсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах,

хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнийг томилох, хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоох журмын төслийг хэлэлцээд, Монгол Улсын шүүхийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-д зааснаар Нийт шүүгчийн чуулганаар хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам батлагдах хүртэлх хугацаанд баримтлах түр журмыг баталж, тус журамд 2 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна.

Шинэчлэн батлагдсан хуулиар Танхимын тэргүүнийг Шүүгчдийн зөвлөгөөнөөс сонгохоор заасны дагуу Улсын дээд шүүхийн Танхимын тэргүүнүүдийг сонгох асуудлыг мөн хэлэлцэж, олонхын саналаар Эрүүгийн хэргийн танхимын тэргүүнээр шүүгч Ч.Хосбаяр, Иргэний хэргийн танхимын тэргүүнээр шүүгч Г.Алтанчимэг, Захиргааны хэргийн танхимын тэргүүнээр шүүгч Ч.Тунгалаг нарыг сонгов.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д бүх шатны шүүхийн нийт шүүгчээс бүрдсэн Нийт шүүгчийн чуулганыг хоёр жил тутам зохион байгуулахаар заасны дагуу Нийт шүүгчийн чуулганыг зохион байгуулах ажлын хэсгийн гишүүнээр шүүгч Д.Эрдэнэбалсүрэн, Д.Мөнхтуяа нарыг Шүүгчдийн зөвлөгөөнөөс сонгож, Нийт шүүгчийн чуулганыг 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүнийг сонгосон.

Мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт зааснаар Улсын дээд шүүхийн дэргэд Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн ажиллаж эхэлсэн бөгөөд дээрх хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтад заасны дагуу Хүрээлэнгийн захирлаар Н.Отгончимэгийг томилох асуудлыг Улсын дээд шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөнд танилцуулж, томилсон байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах болон анхан шатны шүүхээс тус бүр хоёр шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгохоор хуульчилсны дагуу Шүүгчдийн зөвлөгөөний 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр шүүгч Б.Ундрахыг, Сахилгын хорооны гишүүнээр шүүгч Г.Цагаанцоожийн нэрийг дэвшүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд Нийт шүүгчийн чуулганд оролцсон шүүгчдийн санал хураалтаар Шүүхийн ерөнхий зөвлөл болон Сахилгын хорооны шүүгч гишүүнээр сонгогдсон байна.

2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор шүүх эрх мэдэл, хууль сахиулах алба хаагчдын Үндэсний чуулган зохион байгуулагдсан бөгөөд тус чуулганаар “Шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдал ба хуулийн засаглал”, “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаа ба хүний эрх, эрх чөлөө”, “Хуульч бэлтгэх тогтолцоо ба хуульчийн сахилга, хариуцлага” сэдвүүдээр хэлэлцэж, салбар хуралдаанаас гарсан санал дүгнэлтийг оролцогчдод танилцуулж, Үндэсний чуулганаас зөвлөмж гаргасан байна. Чуулганд Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Танхимын тэргүүн, шүүгч нар, Тамгын газрын дарга, хэлтэс албаны дарга нар оролцож, Ерөнхий шүүгч Д.Ганзориг “Шүүхийн шинэчлэл: Бие даасан байдал, чиг үүрэг, хариуцлага” сэдвээр илтгэл тавив.

Тайлангийн хугацаанд Ерөнхий шүүгчийн ажлын албанд нийт 165 хэрэг хүлээж авч, хариу өгсөн байна. Үүнд:

1. Иргэний хэрэг: Нийт 76 хэрэг хүлээж авч, 75 хэргийн хариуг өгч, одоогоор хэргийн үлдэгдэлгүй.
2. Захиргаа хэрэг: Нийт 31 хэрэг хүлээж авч, 31 хэргийн хариуг өгч, одоогоор хэргийн үлдэгдэлгүй.
3. Эрүүгийн хэрэг: Нийт 58 хэрэг хүлээж авч, 58 хэргийн хариуг өгч, одоогоор хэргийн үлдэгдэлгүй байна.

Ерөнхий шүүгчийн ажлын алба эрүү, иргэн, захиргааны хэрэг хүлээн авсан байдлыг 2010-2021 оноор авч үзвэл:



Албан бичиг, өргөдөл, гомдлыг хүлээн авч зохих журмын хариуг өгсөн байна.



Улсын дээд шүүхийн дотоод аудитор нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, гарч болох алдаанаас сэргийлэх, дотоод хяналтын сул талыг сайжруулахад чиглэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг Засгийн газрын тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрэм, Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Санхүүгийн хяналт шалгалтын стандарт", "Улсын салбарын дотоод аудитын аргачлал"-ын хүрээнд хэрэгжүүлж, бүхий л үйл ажиллагааг тулган шалгаж, баримтжуулан батлагдсан стандартыг мөрдөн ажиллалаа.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч /төсвийн ерөнхийлөн захирагч/-ийн захирамжаар Дотоод аудиторын жилийн ажлын төлөвлөгөөг батлуулж ажиллав.

Үүнд:

- Шүүхийн захиргааны хяналт-шинжилгээний сар тутмын мэдээ"-ний хэрэгжилт;
- Төрийн өмч хөрөнгийн тооллого, хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдалд;
- Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь гарган цахимаар мэдүүлсэн байдал;
- Шилэн дансны хуулийн хэрэгжилт;
- Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд "Цахим оффис" системийг бүрэн хэрэглэж хэвшсэн байдал зэрэг.

Аудитад хамрагдсан хэлтэс, албан хаагчдад илэрсэн зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байхыг анхааруулж, улмаар зөвлөмжийн биелэлтийг хангаж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.



ХОЁР.ТАМГЫН ГАЗАР

2.1. ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ УДИРДАХ ЧИГЛЭЛЭЭР:

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан аргачлал, зааврын дагуу боловсруулан баталж, 94.6 хувийн гүйцэтгэлтэйгээр ханган биелүүлж ажиллалаа.

Тамгын газрын дарга 2021 онд хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **160** тушаал, үүнээс үндсэн үйл ажиллагааны чиглэлээр **43**, хүний нөөцийн удирдлагын чиглэлээр **117** тушаал тус тус гарсан бөгөөд тушаалын төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж ажилласан байна.

Түүнчлэн, Тамгын газрын даргын 2021 оны А/01 дугаар тушаалын хавсралтаар “Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэх зарим асуудлын бэлтгэл хангах журам”-ыг, 2021 оны А/06 дугаар тушаалын хавсралтаар “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчийн лавлагаа хүсэхэд бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт”-ыг, 2021 оны А/10 дугаар тушаалын хавсралтаар “Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дүрэм”-ийг, 2021 оны А/12 дугаар тушаалын хавсралтаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг, 2021 оны А/19 дүгээр тушаалын хавсралтаар “Монгол Улсын Их Хурлын нөхөн сонгуульд нэр дэвшигчийн лавлагаа хүсэхэд бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт”-ыг тус тус батлав.

Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал авахаар ирүүлсэн “Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн үед хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх журам”-ын төсөл, “Шүүхийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх журам”-ын төсөлд тодорхой саналыг бичгээр өгч ажиллажээ.

Авлигын эсрэг хууль, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-д заасны дагуу шүүгч, захиргааны албан хаагчдаас “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг 2020 оны байдлаар шинэчлэгдсэн маягтаар гаргуулан авч, **22** шүүгчийн материалыг Шүүхийн ерөнхий зөвлөлд, **49** захиргааны албан хаагчийн материалыг Тамгын газарт зохих журмын дагуу хадгалж байна. Мөн төрийн захиргааны албан тушаалд шинээр томилогдохоор нэр дэвшсэн **28** иргэний “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн

этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг”-ийг Авлигатай тэмцэх газраар хянуулсан байна.

Аж, ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах гэрээнд хууль зүйн дүгнэлт санал өгч ажилласан байна. Тухайлбал:

Автомашинны граж түрээслэх гэрээ,
Газар эзэмшүүлэх гэрээ,
Хөлсөөр ажиллах гэрээ,
Худалдах, худалдан авах гэрээ,
Цахим оффис болон антивирусын програм хангамжийн гэрээ,
“Windows server” үйлдлийн системийн лицензийн гэрээ,
Автомашинны даатгалын гэрээ,
Шүүгчийн амь насны даатгалын гэрээ зэрэг болно.

Тайлангийн хугацаанд бодлогын баримт бичиг боловсруулах чиглэлээр хэд хэдэн ажлын хэсгийг Тамгын газрын даргын тушаалаар байгуулан ажиллуулсан байна. Тодруулбал:

1. Тамгын газрын даргын 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/18 дугаар тушаалаар “Тамгын газрын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийн төсөл боловсруулж, холбогдох зөвлөмж бичгээр гаргах” ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд төсөл, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэхэд бэлтгэн, ажлаа тайлагнасан байна.
2. Тамгын газрын даргын 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн А/22 дугаар тушаалаар “Улсын дээд шүүхийн мэдээллийн технологийн цогц систем” боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд тус ажлын хэсгээс хийгдэх ажилтай холбогдуулан төлөвлөгөө баталж, холбогдох танилцуулгуудыг бэлтгээд байна.
3. Тамгын газрын даргын 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар Гамшгаас хамгаалах түр штабын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан баталсан бөгөөд тус штабаас үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан шуурхай хуралдаж, холбогдох шийдвэрүүдийг гарган удирдлагад танилцуулж, тухай бүрт нь шийдвэрлэж байна.
4. Тамгын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/27 дугаар тушаалаар “Байгууллагын нэрийн ном” (Brand book) хийх ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд Байгууллагын нэрийн номд оруулах материалуудыг нэгтгэн бэлтгэж, төслийг бэлэн болгосон байна.


5. Тамгын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/28 дугаар тушаалаар “Улсын дээд шүүхийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр” боловсруулах ажлын хэсгийг байгуулсан бөгөөд хөтөлбөрийн төслийг боловсруулж, батлуулахад бэлэн болгосон.
6. Тамгын газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар Улсын Их Хурлын 2021 оны “Хууль баталсантай холбогдуулан адах арга хэмжээний тухай” 03 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн 2 дахь заалтын хэрэгжилтийн хүрээнд холбогдох тооцоо судалгаа хийх, шийдвэрийн төсөл боловсруулах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан.

Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Улсын дээд шүүхэд ажиллаж байгаад гавьяаныхаа амралтад гарсан ахмадууддаа Билгийн тооллын хаврын тэргүүн сар шинийн нэгэн “Цагаан сар”-ын баяр болон Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэхэд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан.

Хүлээн авсан хэрэг, албан бичиг, өргөдөл гомдол, явуулсан бичиг

Улсын дээд шүүхийн Тамгын газарт 2021 оны байдлаар **438** өргөдөл гомдол, **1320** албан бичиг, **4165** хавтаст хэрэг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж, Ерөнхий шүүгч, Тамгын газрын даргад танилцуулсны дагуу холбогдох шүүгч, ажилтнуудад тухай бүр шилжүүлэн өгч шийдвэрлүүлснээс гадна **5539** албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлжээ

Улсын дээд шүүхийн хүлээн авсан хэрэг, албан бичиг, өргөдөл гомдол, явуулсан албан бичгийн тоог сүүлийн 10 жилийн байдлаар харуулбал:



Улсын дээд шүүхийн байрны өмнөх нийтийн эзэмшлийн талбайг байгууллагын автомашины зогсоолын хэлбэрээр зөвшөөрөлгүйгээр ашиглаж байсан тул тухайн газрын зөвшөөрлийг зохих журмын дагуу гаргуулахаар Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хандаж, холбогдох бичиг баримтыг хүргүүлээд байна.

Мөн Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, Зайсангийн аманд байрлах Улсын дээд шүүхийн эзэмшлийн газрын хойд талд орон сууцны зориулалтаар барилга барьж буй “Бату констракшн” ХХК, “Бергамо” ХХК-иуд нь барилгын орц, гарцаар ашиглах зам тавихдаа өөрийн эзэмшлийн газраас илүү гаргаж, Улсын дээд шүүхийн эзэмшлийн газар руу давуулан барьсан зөрчил гаргасан тул тусгай зөвшөөрөл бүхий “Эс Эм Стар Геойд” ХХК-иар нэгж талбарын хил, заагийн хяналтын хэмжилт хийлгэн тогтоолгож, 470 м.кв газарт зөвшөөрөлгүй газар ашиглалт явагдаж байгаа талаар тодорхойлолт гаргуулж авсан.

Дээрх газрын тухайд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/74 дүгээр тушаалыг үндэслэн 2016 оны 10 дугаар сарын 17-ны өдөр 0160609 дугаартай гэрчилгээ олгож, 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр “Богдхан уулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд газар ашиглах тухай” 2020/141 дугаартай гурвалсан гэрээ байгуулж байсан бөгөөд тус гэрчилгээ, гурвалсан гэрээний хугацаа дууссан тул Хан-Уул дүүргийн Засаг даргад хугацааг сунгуулах асуудлаар хандаж, хүсэлтээ гаргасан бөгөөд манай байгууллагын хүсэлтийг хүлээн авч сунгах саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн. Мөн Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд сунгуулах талаарх хүсэлтээ хүргүүлээд байна.

Улсын дээд шүүхийн захиргааны ажилтнуудын нийгмийн баталгааг хангах үүднээс шүүгчийн туслах-шинжээч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтэн нарын цалинг 2 дахин нэмэгдүүлэх, бусад захиргааны албан хаагчдийн цалинг 30-40 хувиар нэмүүлэхээр холбогдох байгууллагад хандаж, зохих шийдвэрүүдийг гаргуулсан.

2021 онд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс иргэн Н.Ариунболд, Н.Түмэнбаяр, “Даймонд” ХХК нараас Улсын дээд шүүхэд холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэрэг үүсгэсэн бөгөөд тухайн хэргүүдэд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллан, процесс ажиллагаанд оролцсон бөгөөд хэргүүд шийдвэрлэгдэх шатандаа явж байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт зааснаар Улсын дээд шүүхийн дэргэд Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн байгуулагдан ажиллаж эхэлсэнтэй холбогдуулан Улсын дээд шүүхийн Б байранд 6 өрөөг засварлах, өрөө хооронд сэлгэх, нэмэлтээр “А” байрны 1 давхарт хэргийн өрөөг нэмж гаргах ажлыг зохион байгуулсан.

Мөн Улсын дээд шүүхэд нэвтрэх хаалга нь “Б” байрны үүдний хэсэгт байрлаж байсан бөгөөд тухайн хэсэгт зай талбай хүрэлцээ муу, шүүхээр үйлчлүүлж буй иргэд нэг дор олноор бөөгнөрөх, ковидын халдвар тархаж болзошгүй байсан тул “А” байрны хаалгыг нээж, үүнтэй холбоотой шүүхийн бичиг хэрэг, мэдээлэл лавлагааны ажилтны өрөө, Төрийн тусгай хамгаалалтын газарт албан бичиг хүргүүлж тус газрын ажилтны байрлах хэсэг зэргийг нүүлгэн шилжүүлж, шүүхээр үйлчлүүлж буй иргэдэд ойртуулах зэрэг зохион байгуулалтын ажлыг холбогдох нэгжүүдтэй хамтран ажиллаж хийж гүйцэтгүүлсэн байна.

2.1.1. ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ:

Монгол Улсын шүүхийн тухай хуулиар шүүгчийн амь нас, эрүүл мэндэд нь хохирол учирсан тохиолдолд даатгалын бусад төрлөөс үл хамааран олгогдох заавал даатгагдах албан журмын даатгалын төрлийг хуульчлан тусгасан байдаг тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу цахим хуудсанд нээлттэй сонгон шалгаруулалт зарлан явуулж, хуульд заасан журмаар баримтыг бичгийн шаардлага хангасан оролцогч “Ард даатгал” ХК-тай “Шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал”-ын гэрээг байгуулан, шүүгч бүрт гэрээний хувийг хүргүүлсэн байна.

Монгол Улсын Их хурлын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалын зэрэг зиндааг ахиулж буюу Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнтэй ижил зэрэг зиндаанд ТӨ-IV зэрэгт хамааруулав. Эл асуудлын талаар УИХ-ийн нэгдсэн чуулган болон Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд Тамгын газрын дарга С.Амардэлгэр танилцуулга хийжээ.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал болох коронавируст халдварын сэжигтэй тохиолдол Улсын дээд шүүхийн байранд бүртгэгдсэн тул Улсын онцгой комиссын шуурхай штаб, дүүргийн онцгой комиссын шуурхай штабын заавар, зөвлөмжийн дагуу шүүх, шүүгчийн болон захиргааны ажилтнуудын аюулгүй байдлыг хангах,

Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор гэртээ тусгаарлагдан шинжилгээнд хамрагдах, биеийн эрүүл мэндийн байдлыг тандах нөхцөлийг бүрдүүлэх, шүүхийн байранд ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх болсонтой холбогдуулан 2021 оны 04 дүгээр сарын 16-23, 2021 оны 5 дугаар сарын 03-07, 2021 оны 6 дугаар сарын 10-15-ны өдрүүдэд шүүн таслах болон бусад үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоосон.

Мөн Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд албан хаагчид, иргэд болон хэргийн оролцогчдыг нэвтрүүлэх хаалгыг тусад нь зохион байгуулж, хэрэг болон бичиг баримт хүлээн авах цэг, хэрэг хадгалах өрөө, үйлчилгээний ажилтнуудын ажлын байр зэргийг шинэчлэн зохион байгуулж, холбогдох засвар, үйлчилгээг хийлээ. Энэ хүрээнд ачаа, тээш шалгах рентген аппарат, металл илрүүлэгч хаалга, металл хайгч гар багажуудыг Мэргэжлийн хяналтын газрын зохих зөвшөөрөлтэй ажиллуулж, ариутгал халдваргүйтгэлийн хаалга болон зөөврийн ариутгалын багаж хэрэгслийг тогтмол ажиллуулав. Компьютерын техник хангамжийн ажил хариуцсан ахлах шинжээч Н.Цогтыг “Цацрагийн хяналтын ажилтан”-аар томилж, Монголын цацрагаас хамгаалах нийгэмлэгийн “Рентген шинжилгээний багаж ашиглалт-цацрагийн хамгаалалт О-2, Х2” сургалтад 2021 оны 12 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд сургалтад хамруулав.

Монгол Улсад коронавирус (COVID-19)-ын халдвар бүртгэгдэж, улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан, уг халдварын тархалтаас урьдчилан сэргийлж, “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хяналтын шатны шүүхийн ажиллах түр журам”-ын хэрэгжилтийг ханган ажилласан. Шаардлагатай тохиолдолд Гамшгаас хамгаалах түр штабын хурлыг яаралтай хуралдуулж, үүссэн асуудлыг тухай бүр шийдвэрлэсэн байна.

Коронавирусын халдвар авсан шүүгч, ажилтнуудыг гэрээсээ цахим хэлбэрээр, зайнаас ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжоор хангаж ажиллалаа.

Тайлангийн хугацаанд Шүүн таслах ажиллагааны аюулгүй байдлын хариуцсан шинжээч нь Цагдаагийн ерөнхий газрын Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн албан хаагчид хамтран ажиллаж, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг ханган, шүүн таслах ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэн, хяналтын шатны шүүх хуралдаануудад журам сахиулан ажилласан байна.

Түүнчлэн, иргэн Ц.Оюунгэрэл “Oyungerel Tsedevdamba” пэйж хуудсаараа “Дээд шүүх гэмт хэргийн бирж мөн үү” гэсэн дуу, дүрсний бичлэг бүхий мэдээллийг олон нийтийн сүлжээнд байршуулсантай холбогдуулан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1, 73 дугаар зүйлд заасан шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийн хүрээнд иргэн Ц.Оюунгэрэлийн хийсэн мэдээлэлтэй холбогдуулан зохих арга хэмжээ авахуулахаар Шүүхийн ерөнхий зөвлөлд албан бичиг хүргүүлэв.

2.1.2. ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ:


Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах зорилгоор Тамгын газрын даргын 2021 оны тушаалаар 11 хүнд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, 11 хүнд зэрэг дэвийн нэмэгдэл, 5 хүнд ур чадварын нэмэгдэл шинээр болон нэмэгдүүлэн олголоо.

Тайлангийн хугацаанд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн ажлын албаны дарга Т.Уранцэцэг, Ерөнхий шүүгчийн Иргэний хэргийн шүүн таслах ажиллагаа хариуцсан зөвлөх Д.Тунгалаг, Улсын дээд шүүхийн шүүгч асан, ахмадын зөвлөлийн гишүүн Т.Батсайхан нар Монгол Улсын “Гавьяат хуульч” цолоор, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Р.Ганпүрэв “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр, Танхимын тэргүүний туслах-ахлах шинжээч О.Батсүх, Шүүгчийн туслах-шинжээч З.Оюунгэрэл нар Шүүхийн ерөнхий зөвлөлийн “Хүндэт тэмдэг”-ээр, Архивын ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Тэгшдэлгэр Монгол Улсын дээд шүүхийн “Хүндэт тэмдэг”-ээр тус тус шагнагдсан байна.

Улсын дээд шүүхийн шүүгч, ажилтнуудаас Монгол Улсын төрийн дээд цол, одон медалиар шагнагдсан байдлыг 2010-2021 оны байдлаар үзүүлбэл:

Шагналын нэр	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Гавьяат хуульч	1	1	1	1		2		1				3
Хөдөлмөрийн гавъяаны улаан тугын одон	1	1	2		1		2	1				
Алтангадас одон		2	1		1	2	3	2	1			
Хөдөлмөрийн хүндэт медаль	2	5	6		1	1	1		2		2	
МУДШ-ийн “Хүндэт тэмдэг”	1	3		4				1				1
ШЕЗ-ийн “Хүндэт тэмдэг”	2								3	1		2

“Шударга ёсны элч” тэмдэг											1	
Шүүхийн тэргүүний ажилтан		4		2								
“Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдэг												1



Монгол Улсын Их хурлын 2021 оны 07 сарын 07-ны өдрийн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 69 дүгээр тогтоолоор, анх удаагаа Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргыг “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”-ийн зэрэг зиндаа ТӨ-VI-ийн захиргааны албан тушаалд хамааруулан тогтоосон.

Өнгөрсөн онд шүүхийн сургалтын хөтөлбөр боловсруулах, шүүхийн хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, шүүхийн захиргааны ажилтныг дэмжих ажлын хүрээнд сургалтын агуулгыг шинэчлэх, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, шинээр батлагдсан хууль тогтоомжийн агуулгыг таниулах, хууль хэрэглээний чадвар олгох зорилт тавьж, хэрэгжүүлж ажиллалаа.

Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдаж, хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан “төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх

эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоох” зорилтын хүрээнд Тэргүүн түшмэл, Эрхэлсэн түшмэл, Ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан хаагчид Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Удирдлагын академи, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран зохион байгуулсан “Мэргэшүүлэх багц сургалт”-д хамрагдаж, сертификатаа гардаж авлаа.

Тухайлбал, Удирдлагын академийн Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад Тамгын газрын дарга С.Амардэлгэр, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад Архив, сан хөмрөгийн эрхлэгч-ахлах референт А.Батдэлгэр, Захиргааны хэргийн хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээч Б.Энхбат, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад Шүүгчийн туслах-шинжээч Х.Билгүүн, дунд хугацааны давтан сургалтад референт А.Баярцэцэг, шинжээч Д.Оюунчимэг нар,

Мөн Удирдлагын академи, Сингапурын Үндэсний Их Сургууль (NUS) хамтран зохион байгуулсан “Их өгөгдөлд суурилсан бодлогын иноваци” хөтөлбөрт ахлах референт А.Батдэлгэр, референт А.Баярцэцэг, ахлах шинжээч Б.Оюу-Энх, шинжээч Э.Боролдой, Б.Батчулуун, П.Энх-Амар, Д.Түмэнбадам нар 2021 оны 11 дүгээр сарын 19, 12 дугаар сарын 03-ны өдрүүдэд,

Шүүхийн архив, бичиг хэргийн ажилтныг мэргэшүүлэх болон давтан сургалтын төлөвлөгөөний дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2021 оны 11 дүгээр сарын 29, 12 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулсан сургалтад Архив, сан хөмрөгийн эрхлэгч-ахлах референт А.Батдэлгэр, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах шинжээч Б.Ундрах, Архивын ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Тэгшдэлгэр нар тус тус хамрагдсан байна.

Шүүгчийн туслах-шинжээч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журамд нийцүүлэн “Албан хэрэг хөтлөлтийн онол, арга зүй” сэдэвт хичээл бэлтгэн 2021 оны 6 дугаар сарын 07-ны өдөр Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт, 2021 оны 6 дугаар сарын 08-ны өдөр Захиргааны хэргийн болон Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт, 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр бусад хэлтэс, албадын дарга нар болон шүүхийн захиргааны ажилтнуудад заажээ.

Тухайн сургалтын үеэр “Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлагналт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлагналт” сэдвээр мэдээлэл өгч, харилцан санал солилцсон бөгөөд Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан журам, аргачлалын дагуу шүүхийн захиргааны ажилтнуудад 2021 оны хагас, бүтэн жилийн төлөвлөгөө, тайлан гаргахтай холбогдуулан 2 удаа сургалт зохион байгуулжээ.

Компьютерийн техник хангамжийн ажил хариуцсан ахлах шинжээч Н.Цогт төрийн захиргааны байгууллагын зөвшөөрсөн тусгай хөтөлбөрийн дагуу явагдах цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын сургалтад тус тус хамрууллаа.

Цаашид шүүхийн захиргааны ажилтнуудыг сургалтад тогтмол хамруулах ажлыг зохион байгуулах, давтамжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах юм.

2.1.3. АРХИВЫН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Улсын дээд шүүхийн архивын баримтын хадгалалт, хамгаалалтын стандартыг хангасан техник, тоног төхөөрөмжөөр хангах зорилтыг дэвшүүлэн ажиллалаа.

Тус шүүхийн архив нь 2020 онд батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Иргэн, захиргааны хэргийн баримтын тусгай архивын ажлын заавар”, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн ерөнхий зөвлөл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/18, 34, А/31 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох баримтыг архивт хадгалах заавар”, “Эрүүгийн хэргийн төв болон салбар архивт хадгалагдаж байгаа баримтыг хадгалах хугацааны заавар”-ыг мөрдлөг болгон ажиллав.

Улсын дээд шүүхийн Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлд **156** баримт, Түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлд **124** баримт, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлд **7** баримт, нийт **287** баримтыг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан хүлээн авч, архивын нэгж үүсгэн хадгалсан байна.

Архивын 2021 оны бүтэн жилийн тооллогын дүнгээр хадгаламжийн нэгж нь дараах төрөлд ангилагдаж байна. (Хүснэгтээр харуулав)

д/д	Хадгаламжийн нэгж	Он	Хадгаламжийн нэгжийн тоо
1.	Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн баримт	1996-2020	2274
2.	Түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл	1994-2020	1859
3.	70 жил хадгалах баримтын бүртгэл	1987-2020	64
4.	Дээд шүүх өөрийн эрхээр таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг	1974-2001	305
5.	Иргэний хэрэг	1974-2005	46
6.	Захиргааны хэрэг	2017	3
7.	Кино, гэрэл зураг, дуу, дүрсний баримт	1996-2020	5048
8.	БҮГД		9599

НОМЫН САНГИЙН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Тус шүүхийн номын сан нь Монгол, Англи, Герман хэл дээр улс төр, эрх зүйн онол, шүүх судлал, үндсэн хуулийн эрх зүй, эрүү, иргэн, захиргааны эрх зүй, хууль зүйн мэргэжлийн толь бичиг зэрэг **5841** ном, сэтгүүлийн фондтой.

“Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Зууны мэдээ”, “Үндэсний шуудан”, “Монголын үнэн” “Засгийн газрын мэдээ” “Өглөөний сонин” “Ардчилал таймс”, “Монголын мэдээ” зэрэг 9 төрлийн сонин, “Төрийн мэдээлэл”, Дээд шүүхийн “Мэдээлэл”, “Монголын төр эрх зүй”, “Хууль дээдлэх ёс”, “Төрийн захиргаа” зэрэг 5 төрлийн сэтгүүлийг ангилан байрлуулж, уншигчдад үйлчилж байна.

2021 онд шүүгчид болон ажилтнуудын хэрэгцээ, шаардлагыг судлан үзсэний үндсэн дээр Монгол ном 92 ширхэг, гадаад ном 52 ширхэг нийт 144 ширхэг ном худалдан номын санг баяжуулжээ.

НОМЫН САНД ШИНЭЭР ХҮЛЭЭН АВСАН НОМЫН ЖАГСААЛТ

№	Номын нэр	Зохиогчийн нэр	Хэвлэсэн он	Тоо ширхэг
1.	Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудал	Г.Давааням	2020	3
2.	Хувьцаат компанийн эрх зүйн үндсэн ойлголт	Г.Давааням	2021	3
3.	Морал Хазардын асуудлаас үүдэх толгой компанийн хариуцлага	Г.Давааням	2020	2
4.	Иргэний эрх зүйн тусгай анги	Б.Буянхишиг	2021	3
5.	Иргэний эрх зүйн удиртгал	Б.Буянхишиг	2021	3
6.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй	Б.Буянхишиг	2021	3

7.	Монгол Улсын хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт	Б.Буянхишиг	2021	3
8.	Үүргийн эрх зүй ерөнхий анги	Б.Буянхишиг	2013/2017	2
9.	Хувийн эрх зүй: Онол-арга зүй, эдийн засгийн анализ, харьцуулсан судлал	Б.Буянхишиг	2017	2
10.	Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх явцад эрх зүйн дүгнэлт бэлтгэх	Б.Буянхишиг	2017	2
11.	ХБНГУ-ын Иргэний хууль (кодификацийн бүрэн эх)	Орчуулсан Б.Буянхишиг	2017	2
12.	Монголын эдийн засгийн дэлгэрэнгүй тайлбар толь	Шинжлэх ухааны академи	2021	2
13.	Япон улсын хэрэглэгчийн гэрээний тухай хууль. Орчуулга, товч тайлбар	МУИС, ХЗС Хувийн эрх зүйн цуврал	2020	2
14.	Гэрээний эрх зүй	М.Ванчигмаа	2020	3
15.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь иргэний нэхэмжлэл	М.Ванчигмаа	2021	3
16.	Барилгын ажил гүйцэтгэх гэрээ /фидик-ийн гэрээ болон олон улсын харьцуулалт/	М.Доржханд	2021	2
17.	Орчин үеийн хөдөлмөрийн эдийн засаг (1, 2 дугаар боть)	Н.Содномдорж	2021	3
18.	Захиргааны эрх зүй	МУИС, Ш.Цогтоо	2021	3
19.	Монгол Улсын хувийн эрх зүйн тулгамдсан асуудал: иргэний болон худалдааны хууль тогтоомжийн олон улсын жишиг	МУИС-ийн хууль зүйн сургууль, Хувийн эрх зүйн тэнхим	2019	2
20.	Компанийн эрх зүйн тулгамдсан асуудал (харьцуулсан эрх зүйн зарим сэдэв) илтгэлийн эмхэтгэл	МУИС-ийн Хууль зүйн сургууль	2019	2
21.	Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль	Орчуулсан: Ж.Эрдэнэбулган нар	2021	2
22.	Хууль зүйн шинжлэх ухааны судалгааны арга зүй /гарын авлага/	Хууль зүйн үндэсний хүрээлэн	2018	2
23.	Гэмт хэрэг ба ялын тухай	Чезаре Беккариа	2021	1
24.	Үндсэн хуулийн тайлбар философи	Нэпко хэвлэлийн газар	2020	2
25.	Харьцуулсан эрх зүй судлал	Б.Амарсанаа	2014	2

26.	Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги /сурах бичиг/	Г.Гантөмөр, С.Гантулга, нар /ДХИС/	2020	1
27.	Эрүүгийн эрх зүй: Тусгай анги /сурах бичиг/	Г.Гантөмөр, С.Гантулга, Б.Энхболд	2020	3
28.	Гэрч хохирогчийн аюулгүй байдлын онол, практикийн асуудал	П.Батбаатар	2021	2
29.	Эдийн засгийн гэмт хэрэг – II /Гарын авлага/	МУПЕГ, АDB	2018	2

Гадаад ном

№	Номын нэр	Тоо ширхэг	ISBN-13
1	The Court and the World: American Law and the New Global Realities	1	978-1101912072
2	Nature's Justice: Writings of William O. Douglas (Northwest Readers)	1	978-0870715693
3	The Nature of the Judicial Process	1	978-1481832205
4	All the laws but one: Civil Liberties	1	978-0679767329
5	Reading Law: The Interpretation of Legal Texts	1	978-0314275554
6	Simple Justice: The History of Brown v. Board of Education and Black America's Struggle for Equality	1	978-1400030613
7	The Most Dangerous Branch: Inside the Supreme Court in the Age of Trump	1	978-1524759919
8	A Matter of Interpretation: Federal Courts and the Law - New Edition (The University Center for Human Values Series, 47)	1	978-0691174044
9	Making Our Democracy Work: A Judge's View	1	978-0307390837
10	Supreme Conflict: The Inside Story of the Struggle for Control of the United States Supreme Court	1	978-0143113041
11	The United States Supreme Court: The Pursuit Of Justice	1	
12	Making Your Case: The Art of Persuading Judges	1	978-0314184719
13	Crime and Culpability: A Theory of Criminal Law	2	978-0521739610
14	Criminology of Corruption	1	978-1137517234
15	Contemporary Critical Criminology	1	978-0367443894
16	Introduction to Criminal Justice	1	978-1439839348
17	Digital Forensics: Digital Evidence in Criminal Investigations	1	978-0470517758
18	Law and Judicial Duty	1	978-0674031319
19	Truth, Error, and Criminal Law: An Essay in Legal Epistemology (Cambridge Studies in Philosophy and Law)	1	978-0521730358

20	An introduction to Criminological theory	1	978-1138700215
21	Understanding Criminology	1	978-0335221233
22	The Rule of Law History, Theory and Criticism (Law and Philosophy Library, 80)	1	978-9048112180
23	A Phylosophy of Evidence Law	1	
24	Fair Trails (The European Criminal)	1	
25	A Theory of Justice	1	978-0674000780
26	Freedom's Law	1	978-0674319288
27	General Theory of Law and State	2	978-1584777175
28	Justice as Fairness (A restatement)	1	978-0674005112
29	Natural law and Natural Rights	1	978-0199599141
30	On liberty	1	978-0486421308
31	Taking Rights Seriously: With a New Appendix, a Response to Critics	1	978-0674867116
32	Pure theory of Law	1	978-1584775782
33	Justice for hedgehogs	1	978-0674072251
34	The blackwell Guide to the Philosophy of Law and Legal Theory	1	978-0631228325
35	French Criminal Justice	1	978-1841134291
36	An introduction to Comparative Legal Models of Criminal Justice	1	978-0367597160
37	World Criminal Justice system: A Comparative Survey	1	978-0323356466
38	A theory of the executive branch: Tension and Legality	1	978-0198821984
39	The judge, judiciary and the court :Individual, Collegial and Institutional Judicial Dynamics in Australia	1	978-1108494618
40	Towards Juristocracy: The Origins and Consequences of the New Constitutionalism	1	978-0674025479
41	Judicial Review Handbook	1	978-1509922833
42	Executive Decision-making and the courts	1	978-1509930333
43	Vold's Theoretical Criminology	1	
44	The Idea of Justice	1	
45	Introduction to Criminal Investigation	1	
46	The Concept of Law (Clarendon Law Series)	1	
47	Development as Freedom	1	
48	Dignity: Its History and Meaning	1	
49	The Dignity of Legislation (The Seeley Lectures, Series Number 2)	1	
50	Introduction to the Study of the Law of the Constitution	1	
	Нийт	52	

2.1.4. ЦАГААТГАЛЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Улсын дээд шүүх /Эрүүгийн хэргийн танхим/ 2021 онд прокурорын дүгнэлт бичиж ирүүлсэн нийт 28 цагаатгалын хэргийг хүлээн авч, үүнээс 18 хэлмэгдэгчид холбогдох 16 хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж, 2 хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, 3 хэргийн прокурорын дүгнэлтийг хүлээн авахаас татгалзаж, 1 хэрэгт прокурор дүгнэлтээ буцаан авч, ажиллагаанд 6 хэргийн үлдэгдэлтэй байна.

Хэлмэгдэгчдийн төрөл, садангаас цагаатгуулах хүсэлт 5, нөхөн олговор олгох хүсэлт 10 тус тус ирүүлснийг харьяаллын дагуу зохих байгууллагуудад шилжүүлсэн.

Тайлангийн хугацаанд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн цагаатгалын үнэмлэх олгох талаар хэлмэгдэгчдийн төрөл садан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссуудаар дамжуулан нийт 40 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, үүнээс 18 цагаатгалын үнэмлэх /шинээр 15 үнэмлэх, нөхөн 3 үнэмлэх/ олгож, 22 өргөдөл, хүсэлтэд зохих журмын дагуу хариу өгч буцаасан байна.

Хэлмэгдэгсдийг цагаатгасан байдал:



Цагаатгалын үнэмлэх шинээр болон нөхөн олгосон байдал:



Нийт шүүгчийн хуралдаан, Шүүгчдийн зөвлөгөөний хуралдааны зохион байгуулалтын ажлын чиглэлээр:

Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдаан 11, Шүүгчийн зөвлөгөөн 7, нийт 18 удаа хуралдсан бөгөөд тус хэлтсээс тухай бүрт нь хурлын бэлтгэл ажлыг хангаж ажилласан.

Нийт шүүгчийн хуралдаан, Шүүгчийн зөвлөгөөний үеэр хуралдааны тэмдэглэл хөтлөн, тухайн хуралдаанаас гарах тогтоолын төслийг боловсруулж, Ерөнхий шүүгч, Танхимын тэргүүн, шүүгч, Тамгын газрын даргад танилцуулж, ёсчлуулсан.

Мөн Сонгуулийн ерөнхий хороо, Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэрээ дэвшүүлж ирүүлсэн иргэдийн материал болон Нийт шүүгчийн хуралдаан, Шүүгчдийн зөвлөгөөнд танилцуулагдах материалыг бэлтгэх, шүүгч нарт хүргүүлэх ажлын зохион байгуулан ажилласан.

2.1.5. ТЕХНИК, ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шүүхийн цахим хуудсыг шинэчлэх зорилгоор техникийн даалгавар боловсруулан, тендер шалгаруулалтаар шалгарсан “Бодь электроникс” ХХК-тай хамтран ажлын даалгаврын дагуу гүйцэтгүүлж, Үндэсний дата төвтэй хамтран серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэн холбогдох бэлтгэл ажлыг зохион байгуулж ажилласан.

Хуучин <http://supremecourt.mn/> цахим хуудасны серверийн нууц үг болон мэдээллийн баазыг нөөцлөлт хийн хадгалж аван холбогдох ажилтнуудаар нууцын баталгаа гаргуулж, нууц үгийг өгч шинэ <http://new.supremecourt.mn/> сайтын серверийг шинэчлэн сайжруулах ажлыг зохион байгуулсан.

Тамгын газрын хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаандаа “Цахим оффис”-ийн системийг хэрэглэж байгаа бөгөөд файлын санд шаардлагатай мэдээллийг тухай бүр байршуулж, албан бичгийн төслийг цахим оффист байршуулан холбогдох албан тушаалтнаар хянуулж, бичиг хэрэгт ирсний дараа дугаар өгч албажуулж ажиллажээ. Мөн ажилтнууд “Цахим оффис” систем”-д ажлын цагаа бүртгүүлж хэвшсэн байна.

Төрийн холбооны 26 дугаарлалт бүхий 7 утасны дугаарын эзэмшигчийг шилжүүлэх үйлчилгээг хийлгэж, 11 утасны дугаарыг шинээр авч, суурилуулан ажиллуулсан байна.

Интернетийн урсгалыг төрийн мэдээлэл холбооны хамгаалалттай сүлжээгээр дамжуулан ашиглаж байгаа бөгөөд албан ёсны эрхтэй “касперски” программ хангамжийг ашиглаж хамгаалалтыг сайжруулж ажиллалаа.



Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу цахимаар болон танхимаар хийгдсэн эрүүгийн хэргийн 764, иргэний хэргийн 1964, захиргааны хэргийн 399 шүүх хуралдааны бичлэгийг дуу, дуу-дүрсний буюу цахим хэлбэрээр архивласан байна.

Сүлжээний хурдыг Мобиком компанитай гэрээнд өөрчлөлт оруулж 13,312kbps хурдтай байсныг нэмэгдүүлж 71,680kbps хурдтай болгож 5.4 дахин нэмэгдүүлсэн байна.

2.2. ШҮҮХИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Шүүхийн зохион байгуулалтын хэлтэс нь шүүн таслах ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах нөхцөлийг хангах ажлыг зохион байгуулан, шүүх хуралдааны танхим, техник, зохион байгуулалтын бэлтгэл болон шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны журам сахиулах, хяналтын шатны шүүх хуралдааны тов, шийдвэрлэсэн хэргийн тойм, хяналтын шатны шүүхийн тогтоолыг www.supremecourt.mn болон www.shuukh.mn цахим хуудсанд байршуулах, онлайн шүүх хуралдааны бэлтгэл хангах, шүүх хуралдааны явцыг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулах, шүүн таслах ажиллагааны сар, улирал, хагас, бүтэн жилийн тайлан мэдээ гарган холбогдох байгууллагад хүргүүлэх, хуульд заасан бусад чиг үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын ажлын зохион байгуулалт, албан хэрэг хөтлөлт, хэргийн хөдөлгөөний аргачлал, цахим санд шүүхийн шийдвэр нийтлэх журмын хэрэгжилт, эрүү, иргэн, захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системийн ашиглалтад тус тус хяналт тавин ажиллалаа.

Тайлангийн хугацаанд тус хэлтэс албан бичиг 123, өргөдөл, гомдол, хүсэлт 83-ыг зохих журмын дагуу тус тус хүлээн авч, судлан холбогдох албан тушаалтанд танилцуулан хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг уламжилсан байна.



Нийт 219 албан бичиг, тогтоолын хуулбарт /бүртгэл хөтөлж/ Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандартын дагуу баталгаажуулалт хийсэн байна.

Улсын дээд шүүхийн вэб сайтад хяналтын шатны шүүх хуралдааны эрүүгийн 381, иргэний 1566, захиргааны 248, Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 352, иргэний 841, захиргааны 292 зар, тоймыг тус тус байршуулсан байна.

Шүүхийн зохион байгуулалтын хэлтсийн албан хаагчид шүүх хуралдааны дэг сахиулах, шүүх, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг ханган, шүүн таслах ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах нөхцөлийг ханган ажилласан байна.

Хяналтын шатны шүүх хуралдааны техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангаж, эрүүгийн 402, иргэний 1657, захиргааны 203 хэргийн шүүх хуралдааны тэмдэглэл хөтөлж, шүүх хуралдааны явцыг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулан, шүүх хуралдааны тэмдэглэлийг ёсчлуулан хэргийн оролцогчид хуульд заасан хугацаанд танилцуулж, бүртгэл хяналтын системд байршуулан, шүүгчийн туслахуудад хүлээлгэн өгсөн байна.

Хэргийн оролцогчдоос шүүх хуралдааны дуу, дүрс бичлэгийг хуулбарлан авахыг хүссэн 9 хүсэлтийг зохих журмын дагуу хүлээн авч, хүсэлтийг үндэслэн шүүх хуралдааны бичлэгийг хуулбарлан өгөх асуудлыг Тамгын газрын дарга болон тухайн хэргийг илтгэсэн шүүгчид танилцуулан, хүсэлт гаргагчид баталгааны хуудаст гарын үсэг зуруулан хүлээлгэн өгсөн байна.

Улсын дээд шүүхийн тамгын газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/52 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хяналтын шатны шүүхийн ажиллах түр журам”-ыг баримтлан, улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үеийн шүүх хуралдааныг зайнаас буюу технологи ашиглаж явуулах, хуралдааны оролцогчдыг шүүх бүрэлдэхүүн, нарийн дарга байгаа танхимаас өөр танхимаас, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үеийн шүүх хуралдааныг хэргийн оролцогч өөрөөс шалтгаалах техникийн нөхцөл, бололцоог бүрдүүлсэн тохиолдолд zoom, skype зэрэг техник ашиглан өөрийн байгаа газраас нь шүүх хуралдааны ажиллагаанд оролцуулах боломжийг тус тус ханган ажилласан байна.

Хяналтын шатны шүүхийн 2021 онд хянан шийдвэрлэсэн эрүү, иргэн, захиргааны хэргийн тогтоолуудыг www.shuukh.mn сайтад хууль, журамд заасны дагуу байршуулан ажиллаж байгаагаас эрүүгийн 282, иргэний 1273, захиргааны 129 тогтоол байршуулсан байна.


Тайлангийн хугацаанд хяналтын шатны шүүхийн “Шүүхийн захиргааны хяналт-шинжилгээний сар тутмын мэдээ”-г administration@judcouncil.mn цахим хаягаар, шүүн таслах ажиллагааны улирал, хагас, бүтэн жилийн тайланг “Шүүхийн статистикийн мэдээлэл, тайлан гаргах журам”-ын дагуу шинэчлэгдсэн хураангуй

маягтаар гаргаж, албан бичиг болон цахим хэлбэрээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнд jud_research@judcouncil.mn хаягаар тус тус хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа.

2.3. ШҮҮХИЙН ПРАКТИК СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Тайлангийн хугацаанд нийт 68 судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд өмнөх онуудтай харьцуулахад 36,7 хувиар өссөн дүнтэй байна.

2013 оноос хойших судалгааны дүн мэдээ:



2021 онд хийж гүйцэтгэсэн судалгааны ажлын талаар:

Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар хянагдсан эрүү, иргэн, захиргааны хэргийн дүн, өөрчлөгдсөн, хүчингүй болсон тогтоол, магадлалыг судалсан тухай тоймыг жил бүр хийж гүйцэтгэлээ.

1. Эрүүгийн хэргийн талаарх шүүхийн практикийг судлах ажлын хүрээнд нийт 22 судалгааг хийж гүйцэтгэжээ. Үүнд:

-2020 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан түдгэлзүүлсэн хэргийн судалгаа-3 хуудас;

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр бүлэг “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх журам”-ыг шүүхийн практикт хэрэглэж байгаа байдлын судалгаа-1 хуудас;

-2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 229 дүгээр зүйлийн 229.1.3 дахь заалт, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3-т тус тус заасны дагуу тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт Монгол улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаарх гомдлыг Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа үндэслэлээр шүүгч

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн хэргийн судалгаа /2002-2020 он/-3 хуудас;

-Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн тулгамдаж буй байдлын судалгаа-2 хуудас , хавсралт 10 хуудас;

-Хяналтын шатны шүүхээс 2020-2021.05.19 өдрийг хүртэлх хугацаанд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон хэргийн судалгаа-2 хуудас;

-Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл, Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлээр шийдвэрлэсэн хэргийн судалгаа-2 хуудас;

- Улсын хэмжээний эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны судалгаа /2017-2020 он/-2 хуудас;

-Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хэргийн ажиллагааны тухай хуулиар харилцаа холбооны сүлжээнд болон хувь хүний нууцад халдах тухай хуулийн онолын судалгаа-1 хуудас;

- Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7 дугаар зүйл /Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/-ээр шийдвэрлэсэн хэргийн судалгаа /2016-2020 он/-6 хуудас , хавсралт 8 хуудас;

-Улсын Дээд шүүхээс гаргасан хуулийн тайлбаруудын судалгаа /1993-2010 он/-34 хуудас;

-Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн тогтвортой байдлын судалгаа /2017-2020 он/-2 хуудас;

-Хууль тайлбарлуулахаар ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэсэн байдлын судалгаа /2010-2021 он/-4 хуудас;

-Авлига, албан тушаалын, мөнгө угаах гэмт хэргийн шийдвэрлэсэн байдлын судалгаа /2018-2020 он/ -9 хуудас;

-Анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тойм судалгаа /2002-2020 он/-3 хуудас;

-Баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийн талаарх судалгаа /2020-2021.08 сар/-9 хуудас, хавсралт 72 хуудас;

-Шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан этгээдийг сулласан байдлын талаарх судалгаа /2020-2021.10 сар/-3 хуудас, хавсралт 3 хуудас;

-Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх шатанд оргон зайлсан этгээдийн судалгаа /2020-2021.10 сар/-5 хуудас, хавсралт 151 хуудас;

-Мөнгө угаах гэмт хэргийг анхан, давах, хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн байдлын судалгаа /2017-2021 он/-16 хуудас, хавсралт 75 хуудас;

-Хяналтын журмаар гаргасан гомдлыг танхимын нийт шүүгчдийн хуралдаанаар шийдвэрлэсэн байдлын судалгаа /2021.03.01-2021.12.15 өдрөөр/- 2 хуудас;

-Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаас прокурорт буцаасан хэргийн судалгаа /2020 он/-13 хуудас;

-Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаас прокурорт буцаасан хэргийн судалгаа /2019 он/, Хяналтын шатны шүүх хуралдаанаар хүчингүй болгосон хэргийн судалгаа /2019-2021 он/-9 хуудас;

-НҮБ-аас зарласан авлигын эсрэг олон улсын өдөрт зориулан Монгол Улсын Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлигын эсрэг үндэсний чуулган-2021” арга хэмжээнд Танхимын тэргүүн Ч.Хосбаярын “Авлигын гэмт хэргийг шийдвэрлэхэд анхаарах асуудал” сэдэвт илтгэл, хэлэлцүүлэгт зориулсан судалгаа /2018-2021 он/-16 хуудас.

2. Иргэний хэргийн талаарх шүүхийн практикийг судлах ажлын хүрээнд нийт 26 судалгаа хийж гүйцэтгэснээс хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхтэй холбоотойгоор хэрэг маргааны төрлөөр ижил төстэй хэргийн судалгаа, хуулийн зүйл, хэсэг, заалтын түүхчилсэн 18 судалгааг тус тус хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

-Иргэний хуулийн 58-60 дугаар зүйлд заасан хүчин төгөлдөр бус гэж тооцож болох хэлцлүүдийн талаар түүвэр судалгаа-3 хуудас,

-Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн ажил гүйцэтгэх гэрээний судалгаа /2018-2020 он/-2 хуудас, 10 тогтоол,

-Хяналтын шатны шүүхийн иргэний хэргийн танхимын 2013-2020 онд хянан шийдвэрлэсэн хэргийн танилцуулга-2 хуудас;

-Шүүхэд нотлох баримт үнэлэх эрх зүйн зохицуулалт, стандартын талаарх судалгаа-5 хуудас;

-Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гаргасан өргөдөл, гомдолд хариу өгсөн байдлын талаарх судалгаа 2 хуудас;

-Улсын Дээд шүүхээс хууль тайлбарласан тогтоол, зөвлөмж, тайлбаруудын хүчинтэй эсэх талаарх судалгаа-4 хуудас;

-Хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн өв хүлээн авах, хүлээн авахаас татгалзах тухай судалгаа /2018-2020 оны байдлаар/ -5 тогтоол,

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн судалгаа /төлбөр төлөгч-хуулийн этгээдийн хөрөнгөөс төлбөр гаргуулах/-4 хуудас,

-Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхтэй холбогдуулж барьцаа, фидуцийн гэрээтэй холбоотой хэргийн судалгаа /2018-2021 он/ -10 хуудас, 6 тогтоол,

-Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхтэй холбогдуулж Гэр бүлийн хэрэг маргаантай холбоотой судалгаа /2018-2021 он/-70 тогтоол,

-Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхтэй холбогдуулж Татварын өршөөлийн тухай хуультай холбоотой хэргийн судалгаа /2008-2021 он/-6 хуудас, 7 тогтоол,

-Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхтэй холбогдуулж хүүхдийн эцэг тогтоолгох тухай маргаантай холбоотой хэргийн судалгаа /2018-2021 он/-15 тогтоол,

-Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхтэй холбогдуулж барьцааны гэрээ, фидуци, барьцаалан зээлдүүлэх газар бус-банк, эрх бүхий хуулийн этгээдээс олгосон зээлийн тухай маргаантай холбоотой хэргийн судалгаа /2018-2021 он/-15 хуудас, 32 тогтоол,

-Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхтэй холбогдуулж барьцааны гэрээ буюу ломбардны тухай маргаантай холбоотой хэргийн судалгаа /2018-2021 он/-3 хуудас, 5 тогтоол,

-Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхтэй холбогдуулж хилс хэргийн цагаатгалтай холбоотой хэргийн судалгаа /2018-2021 он/-19 хуудас, 27 тогтоол,

-Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхтэй холбогдуулж хувьцаа болон худалдах, худалдан авах тухай маргаантай холбоотой хэргийн судалгаа /2018-2021 он/-1 хуудас, 10 тогтоол,

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхтэй холбогдуулж Иргэний хуулийн 451.1, 452.1-д заасан зээлийн гэрээтэй судалгаа /2018-2021 он/-50 тогтоол,

-Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхтэй холбогдуулж Хөдөлмөрийн маргаантай холбоотой хэргийн судалгаа /2017-2021 он/-80 тогтоол,

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхтэй холбогдуулж Гэр бүлийн хэрэг маргаантай холбоотой судалгаа /2016-2021 он/-41 тогтоол,

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхтэй холбогдуулж Иргэний хуулийн 380.1-д заасан тээвэрлэлтийн гэрээтэй холбоотой хэргийн судалгаа /2016-2021 он/-1 хуудас, 13 тогтоол,

-Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхтэй холбогдуулж Амьтны аймагт учруулсан гэм хорын хохиролтой холбоотой хэргийн судалгаа /2003-2021 он/-

-Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхтэй Иргэний хуулийн 157.3, 160.1.6-д заасантай холбоотой барьцааны үл хөдлөх эд хөрөнгийг чөлөөлсөнтэй холбоотой хэргийн судалгаа /2016-2021 он/-6 тогтоол,

-Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхтэй холбогдуулж Биткойнтой холбоотой хэргийн судалгаа /2015-2021 он/ 1 тогтоол,

3. Захиргааны хэргийн талаарх шүүхийн практикийг судлах ажлын хүрээнд нийт 18 судалгааг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

-Улсын Дээд шүүхээс Захиргааны эрх зүйн салбарын хуульд хийсэн албан ёсны тайлбар /1992-2010 он/-7 хуудас;

-Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн Захиргааны эрх зүйн маргааны судалгаа /2019-2020 он/-2 хуудас;

-Улсын хэмжээний шүүн таслах ажиллагааны танилцуулга /2017-2019 он/-2 хуудас;

-Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжийн судалгаа / Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх асуудлын хүрээнд гаргасан ерөнхий шүүгчийн захирамж, тушаал/-5 хуудас;

-Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн сонгуулийн маргааны судалгаа /2016-2020 он/-5 хуудас;

-Улсын Дээд шүүхийн таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэх хэргийг хуралдаанд бэлтгэх ажиллагааны дараалал /аргачлал боловсруулах/-2 хуудас;

-Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоосон болон хэрэг үүсгэсэн, буцаасан захирамжуудын судалгаа /шүүхэд мэдүүлэх эрх/-17 хуудас;

-Шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтооход харгалзан үзэх шалгуур үзүүлэлтийн талаарх танилцуулга;

-Хяналтын шатны шүүхээр шийдвэрлэгдсэн НХААГ хариуцагчтай маргааны судалгаа /2013-2020 он/ -3 хуудас;

-Шүүхэд нотлох баримт үнэлэх эрх зүйн зохицуулалт, стандарт/захиргаа/-3 хуудас;

-Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар 2014 оны Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2, 32.6, 32.7, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2 дахь хэсэгт заасан эрх зүйн зохицуулалтуудаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн судалгаа /2016-2020 он/-1 хуудас;

-Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн үйлчлэлд хамрагдсан ААН-үүдийн нөхөх олговрын асуудлыг Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13-аар шийдвэрлэх эрх зүйн боломжтой эсэх шийдлийн судалгаа-3 хуудас;

-Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэр гаргахдаа хэрэглэсэн Барилгын тухай хуулийн судалгаа-2 хуудас;

- Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэр гаргахдаа хэрэглэсэн хууль /Газрын тухай хуулийн 21.2.2, 21.2.3, 21.2.4/-ийн судалгаа-1 хуудас;

-Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.8, 45 дугаар зүйлийн 45.1-ийг хэрэглэж шийдвэрлэсэн хэргийн судалгаа / 2016-2021 он/-2 хуудас;

-Захиргааны хэргийн шүүх хуралдаанаар төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв байгууллага хариуцагчаар оролцсон хэргүүд /2016-2021 он/-3 хуудас;

-Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар захиргааны хэм хэмжээ тогтоосон акттай холбоотой маргааныг хянан шийдвэрлэсэн статистик судалгаа / 2016-2020 он/-2 хуудас;

-Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тойм судалгаа /2004-2020 он/-5 хуудас.

Бусад судалгааны ажлын хүрээнд:

1. Дараах хуулийн төслийг танхимын шүүгч нарт хувиран тарааж, саналуудыг нэгтгэн холбогдох байгууллагад уламжилсан.

-Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

-Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

-Орон тооны бус зөвлөл байгуулах тухай, Зөвлөл ажиллах журмын төсөл;

-Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл;

-Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл;

-Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;

-Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл;

-Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл;

-Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төсөл;

-Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл;

-Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл.

2. Улсын дээд шүүхийн нэрийн ном /брэнд бүүк/ хийж гүйцэтгэх, Улсын дээд шүүхийн шинэ цахим хуудсыг хүлээн авах, “МУ-ын дээд шүүхийн төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр”, “МУ-ын дээд шүүхийн төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг боловсруулах, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5 дахь заалтын хэрэгжилтийг судалж, санал гаргах тус тус ажлын хэсэгт орж ажиллаж байна.

3. Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжуудын хуулбарыг авч, SPSS программд 19 өгөгдөлд шивж оруулан дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн.

Мөн “Монголын төр, эрх зүй” сэтгүүлийг эрхлэн гаргах журмын төслийг боловсруулж батлуулж, сэтгүүлийн зөвлөлийг байгуулсан.

Хууль тогтоомжийн системчлэлийн ажлын чиглэлээр:

2021 онд Монгол Улсын хууль 162 хүлээн авч, үүнээс шинээр баталсан болон шинэчлэн найруулсан 24 хууль, 126 хуульд нэмэлт, өөрчлөлт орж, 12 хууль хүчингүй болсныг эх хуульд тухай бүрт нь хийхийн зэрэгцээ “Цахим оффис” систем” дахь хуулиудад өөрчлөлтийг орууллаа.

Улсын Их хурлын тогтоол 87;

Засгийн газрын тогтоол 6;

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, тогтоол 11;

Төрийн мэдээлэл сэтгүүлийн 45 дугаарыг хүлээн авч, эх хувь болон нэгдсэн санд оруулсан байна.


Улсын Их хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндсэн хуулийн цэцээс манайд ирүүлж байгаа Монгол Улсын хууль, Улсын Их хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, тогтоол, “Төрийн мэдээлэл” сэтгүүлүүдийг дугаар бүрээр нь хүлээн авч шүүгч, ажилтнуудад эх хувиар болон дотоод сүлжээгээр дамжуулан ашиглуулж, лавлагаа өгч, Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхим болон Практик судлалын хэлтсээс гаргасан тойм, зөвлөмжүүдийг тухай бүрт нь цахим санд оруулан шүүхийн мэдээллийн санг баяжуулан ажиллаж байна.

Ном товхимол, сэтгүүл эрхлэн гаргах чиглэлээр:

“Монголын төр, эрх зүй” сэтгүүлийн 2020 оны 4, 2021 оны 1, 2 дугаар улирлын дугаар, мөн Тусгай дугаарыг эрхлэн хэвлүүллээ. Энэхүү тусгай дугаарт Монгол Улсын дээд шүүхийн үе үеийн Ерөнхий шүүгчдийн түүхт ой, томоохон арга хэмжээнд зориулан хэлсэн үг, илтгэлийг эмхтгэн гаргалаа.

2.4. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ЧИГЛЭЛЭЭР:

Улсын дээд шүүхийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс нь 2021 оны бүтэн жилийн дүнгээр Улсын дээд шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагааны талаар давхардсан тоогоор нийт **1874 мэдээ мэдээлэл, нийтлэл ярилцлага, нэвтрүүлэг** нийтлүүлж нэвтрүүлжээ. Энэ нь өнгөрсөн 2020 оны дүнгээс 2 дахин давсан үзүүлэлт байна.



Улсын дээд шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагаа, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвхөн мэдээ, мэдээллийн хувьд давхардсан тоогоор өдөр тутмын сонинд **89**, телевизэд **299**, радиод **131**, вэб сайтуудад **1275** мэдээ, мэдээлэл бэлтгэн нийтлүүлж нэвтрүүлсэн байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн зохицуулалтын дагуу шүүхэд хийгдэж буй шинэчлэл, үйл ажиллагаа, шүүн таслах ажиллагааны практик, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуультай холбоотой зэрэг асуудлаар Монголын Үндэсний олон нийтийн телевиз, Eagle зэрэг телевизүүдтэй хамтран нийт 18 нэвтрүүлгийг олон нийтэд хүргэсэн байна.

Мөн МҮОНТ-тэй хамтран бэлтгэдэг “Монгол Улсын нэрийн өмнөөс” нэвтрүүлгийн цаг Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран хийх болсноор 10 минутаар нэмэгдэж, нийт 20 минут болж, 14 хоногт 1 удаа эфирээр цацагдах болсон.

2021 онд МҮОНТ-ээр “Монгол Улсын нэрийн өмнөөс” нэвтрүүлгийн **13** дугаарыг бэлтгэн олон нийтэд хүргэжээ. Үүнд:

1.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн онцлог, зарим зохицуулалтын талаар- Улсын Дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, Д.Мөнхтуяа - 2021.03.09

2.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулагдсаны 10 жилийн ойтой холбоотой тус шүүхээс хийсэн сурвалжилга - 2021.03.23

3.Гэрээний харилцаатай холбоотой маргаан-Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх - 2021.04.07

4.Шүүхийн байрны асуудал-Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх - 2021.04.20

5.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн зарим зохицуулалт, Нийт шүүгчийн чуулганы талаар - Улсын дээд шүүхийн шүүгч Г.Банзрагч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Тамгын газрын дарга С.Билгүүн - 2021.05.25

6.Хүний эрх эрүүдэн шүүлт, зорчих эрх хязгаарлах ялын талаар- Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Батаа, М.Мөнхбаатар - 2021.06.08

7.Хөвсгөл аймгийн шүүхээс бэлтгэсэн ярилцлага, сурвалжилга - Хөвсгөл аймгийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ж.Ганчимэг, Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Ууганбаяр – 2021.09.07

8.Сэлэнгэ аймгийн шүүхээс бэлтгэсэн ярилцлага, сурвалжлага - Сэлэнгэ аймаг дахь Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Д.Буянжаргал, Сэлэнгэ аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Л.Одбаатар, Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Л.Энхтайван – 2021.09.28

9.Нийт шүүгчийн анхдугаар чуулган, үр дүн - Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.Буд, Сэлэнгэ аймаг дахь Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Д.Буянжаргал, Говьсүмбэр аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч З.Ганзориг - 2021.10.19

10.Хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох - Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ш.Оюунтуул, Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Азбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Мэдээллийн технологи, хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн дарга Э.Амарсанаа – 2021.11.02

11.Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн байрны нөхцөл байдал, тулгамдсан асуудал - Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Ганболд, Тамгын газрын дарга Л.Наянтай – 2021.11.18

12.Согтуурах, мансуурах донтой хүний албадан эмчилгээг шүүхийн журмаар дуусгавар болгох үйл явц, шүүх хуралдааны үйл ажиллагаанаас хийсэн сурвалжлага - Төв аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Д.Алтантуул, шүүгч Д.Отгончулуун, Д.Мөнхбүрэн, Б.Түвшинжаргал, Н.Гэрэлтуяа – 2021.12.02

13.Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ - Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлагч Ж.Мөнхсайхан, Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлагч Д.Мөнхцэцэг, Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлагч Б.Буянхишиг, Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлагч Ж.Лхамдолгор, Шүүхийн ерөнхий зөвлөлийн эвлэрүүлэн зуучлал хариуцсан референт Р.Ичинхорлоо - 2021.12.16

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн дагуу зохион байгуулагдсан “Нийт шүүгчийн чуулган”, Шүүхийн сургалт судалгаа мэдээллийн хүрээлэнгийн үйл ажиллагаа, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай холбоотой асуудлаар Улсын дээд шүүхийн Танхимын тэргүүн, шүүгчид, Шүүхийн сургалт судалгаа мэдээллийн хүрээлэнгийн захирал зэргийг 5 нэвтрүүлэгт оролцуулах ажлыг зохион байгуулжээ. Үүнд:

1.Монгол Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Б.Батцэрэн нар МҮОНТ-ийн “Цаг үе, үзэл бодол” нэвтрүүлэгт 2021 оны 10 дугаар сарын 17-ны өдөр оролцож, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар үзэл бодлоо илэрхийлж ярилцлага өгсөн.

2.Монгол Улсын дээд шүүхийн шүүгч, Нийт шүүгчийн чуулганыг зохион байгуулах Ажлын хэсгийн ахлагч Д.Мөнхтуяа Eagle телевизийн “Зочны цаг” нэвтрүүлэгт 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдөр оролцож, Нийт шүүгчийн чуулганы талаар ярилцлага өгсөн.

3.Монгол Улсын дээд шүүхийн шүүгч, Нийт шүүгчийн чуулганыг зохион байгуулах Ажлын хэсгийн ахлагч Д.Мөнхтуяа “ММ агентлаг”-ийн “Онцлох зочин” нэвтрүүлэгт 2021 оны 10 дугаар сарын 8-ны өдөр оролцож, Нийт шүүгчийн чуулганы талаар ярилцлага өгсөн.

4.Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэнгийн захирал Н.Отгончимэг Eagle телевизийн "Зочны цаг" нэвтрүүлэгт 2021 оны 8 дугаар сарын 17-ны өдөр оролцож, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн үйл ажиллагааны талаар ярилцлага өгсөн.

5.Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэнгийн захирал Н.Отгончимэг МҮОНТ-ийн "Иргэдийн эрх зүйн боловсролд" шууд нэвтрүүлэгт 2021 оны 8 дугаар сарын 19-ны өдөр оролцож, Хүрээлэнгийн үйл ажиллагааны талаар ярилцлага өгсөн.

Илтгэл, ярилцлагын тухайд:

1. Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзоригийн “Шүүхийн шинэчлэл: Бие даасан байдал, чиг үүрэг, хариуцлага” илтгэл бүрэн эхээрээ Supremecourt.mn сайтаас гадна Unuudur.mn, itoim.mn, Niitlel.mn, Snews.mn сайтуудад, хэсэгчилсэн байдлаар “Өдрийн сонин” 2021.10.18 №200/6822/, montsame.mn, 24tsag.mn зэрэг сайтуудад нийтлэгджээ.

2.Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн Танхимын тэргүүн Ч.Хосбаярын “Хүний эрх ба шүүх эрх мэдэл” илтгэл бүрэн эхээрээ Supremecourt.mn сайтаас гадна zindaa.mn, zugii.mn, ikon.mn, updown сайтуудад 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр нийтлэгдсэн.

3.Улсын дээд шүүхийн шүүгч Д.Эрдэнэбалсүрэнгийн “Шүүхийн өөрөө удирдах ёсны дээд тогтолцоо нь Нийт шүүгчийн чуулган”ярилцлага “Өдрийн сонин”-ы 2021 оны 10 дугаар сарын 6-ны №193/6815/ дугаарт болон ikon.mn, eguur.mn, snews.mn, itoim.mn, dnn.mn, tac.mn, niitlel.mn зэрэг сайтуудад нийтлэгджээ.

4.Улсын дээд шүүхийн дэргэдэх Сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Н.Отгончимэгийн “Хүрээлэн шүүгчдийн хэрэгцээнд тулгуурлан судалгаа, сургалт хийж, шүүн таслах ажлын чанарыг сайжруулахад тусална” ярилцлага “Өдрийн сонин”-ы 2021 оны 8 дугаар сарын 19-ны №158/6780/ дугаарт болон ikon.mn, zindaa.mn, eguur.mn, 24tsag.mn, itoim.mn, snews.mn, dnn.mn сайтуудад нийтлэгджээ.

5.Нийт шүүгчийн чуулганыг зохион байгуулах хүрээнд Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч М.Пүрэвсүрэнгийн “Нийт шүүгчийн чуулган зохион байгуулах хууль зүйн зайлшгүй шаардлага байна” ярилцлага “Өнөөдөр сонин”-ы 2021 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн №196/7244/ дугаарт, gogo.mn,snews.mn, unuudur.mn сайтад нийтлэгдсэн.

Шүүхийн шийдвэрийн хураангуй боловсруулах, нийтлэх талаар:

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 22.10, 22.11 дэх хэсэгт зааснаар шүүхийн шийдвэрийн 2 хураангуйг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлсэн. Үүнд:

1.Б.Мөнхцэлмэгийн гомдолтой захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хураангуйг Eguur.mn, ergelt.mn, Zuv.mn, Unuudur.mn, mnb.mn, eagle.mn, zindaa.mn, tsahiur.mn сайтуудад 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр нийтэлсэн байна.

2.Иргэдийн оролцооны нэгдэл нам (ИОНН) үүсгэн байгуулсныг бүртгүүлэх өргөдлийг шийдвэрлэсэн тухай тогтоолын хураангуйг дэлгэрэнгүй болон мэдээлэл маягаар gogo.mn, zuv.mn, news.mn, isee.mn, dnn.mn, toim.mn, dardas.mn, zaag.mn, sonin.mn, itoim.mn, zaluu.mn, livetv.mn, shuud.mn, ikon.mn, unuudur.mn сайтуудад 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр нийтэлжээ.

“Шүүхийг сурвалжлах нь” цуврал сургалтын талаар:

Улсын дээд шүүхээс зохион байгуулдаг “Шүүхийг сурвалжлах нь” сургалтыг сэтгүүлчдийн болон Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхимын тэргүүнүүд, шүүгчдэд танилцуулан сэдвийг боловсруулж, зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан байна.

Олны анхаарал татсан 10 хэргийн шүүх хурлыг сурвалжлах хүсэлтийг нийт 61 хэвлэл мэдээллийн байгууллагын зүгээс бичгээр болон амаар гаргасан. Журмын дагуу 9 хэргийн /үүнээс 1 нь маш нууцтай хэргийн шүүх хуралдааны нээлт, шийдвэр уншиж сонсох хэсэг/ шүүх хуралдааныг шүүх бүрэлдэхүүний зөвшөөрсний дагуу нийт 55 хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчид сурвалжилсан байна.

Бүтэн жилийн дүнгээр сонин, сайтаар гарсан шүүхийн талаарх материалд судалгаа хийж, шүүхийн ил тод нээлттэй байдлыг хангах, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах, холбогдох хууль тогтоомж, хандлага, харилцаа, анхаарах зүйл зэрэг агуулгыг нэгтгэсэн “Шүүхээс хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах нь” сэдвээр хичээлийг Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Р.Ганпүрэв шүүхийн захиргааны ажилтны сургалтад 2021 оны 9 дүгээр сард заасан. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан уг сургалтад 80 гаруй суралцагч оролцсон байна.

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, холбогдох бусад албан тушаалтнуудад сонин, сайтын **212** өдрийн тойм бэлтгэн өдөр тутам хүргэж, мэдээллээр хангаж ажиллалаа.

Улсын дээд шүүхийн supremecourt.mn сайтад нийт **130** мэдээ, мэдээлэл олон нийтэлснээс гадна албан ёсны facebook, twitter хаягтаа байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах үүргээ тогтмол хэрэгжүүлсэн байна.

2.5.ШҮҮХИЙН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Шүүхийн гадаад харилцаа жилээс жилд өргөжин тэлж шүүгч, ажилтнууд тив дэлхийн болон олон улсын бүсийн чуулга уулзалт, эрдэм шинжилгээний бага хуралд оролцож шүүн таслах ажиллагааны талаарх туршлага судлах ажил өргөжиж байна. Цар тахлын улмаас энэ жил төлөвлөгдөөд байсан гадаад улсад хийх байсан айлчлал болоод сургалтууд тодорхойгүй хугацаагаар хойшлогдож, зарим уулзалтууд цахим хэлбэрээр зохион байгуулагдаж байна. Тухайлбал:

-шүүгч Д.Мөнхтуяа, Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Алтанжигүүр, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.Дуламсүрэн, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга Д.Тулга нар Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/-аас 2021 оны 04 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулсан “Шүүгч эмэгтэйчүүдийн холбоо” сэдэвт олон улсын цахим хуралд шүүгч Д.Мөнхтуяа илтгэл тавьж оролцсон;

-ОХУ-ын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагддаг Санкт-Петербургийн эрх зүйн форум 2021 оны 05 дугаар сарын 18-22 өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулагдсан хуралд;

-Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг Бүгд Найрамдах Киргиз улсын Ташкент хотноо 2021 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулагдсан Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Дээд шүүхийн тэргүүн нарын 16 дахь удаагийн уулзалт;

-шүүгч Ц.Цогт ОХУ-ын Дээд шүүхээс 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан “Ази, Номхон далайн бүс нутгийн хууль, эрх зүй, шударга ёс ба эдийн засгийн интеграц, хөгжил” сэдэвт Ази, Номхон далайн бүс нутгийн олон улсын эрх зүйн 11-р форумд;

-шүүгч Б.Батцэрэн Бүгд Найрамдах Узбекистан Улсын Ташкент хотноо 2021 оны 11 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд тус улсын Дээд шүүх, Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн алба хамтран зохион байгуулж буй “Эрүүгийн шударга ёсны асуудлаарх Төв Азийн мэргэжилтнүүдийн 8 дугаар сургалт уулзалт”-д;

-Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга Д.Тулга цахим хэлбэрээр БНЭУ-ын Лакноу хотноо 2021 оны 11 дүгээр сарын 5-11-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Дэлхийн Ерөнхий шүүгч нарын дээд хэмжээний уулзалт”-д;

-Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Д.Эрдэнэбалсүрэн нар цахим хэлбэрээр 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Олон Улсын Эрүүгийн шүүх, БНСУ-ын Дээд шүүхтэй хамтран зохион байгуулсан “Ромын дүрэм, Олон Улсын Эрүүгийн шүүхийн талаарх Ази, Номхон далайн бүсийн орнуудын шүүхийн шүүгч нарын семинар”-т тус тус оролцуулах ажлыг зохион байгууллаа.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд:

-шүүгч Г.Банзрагч, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга Д.Тулга нар Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/-ын Ардчилсан институт, хүний эрхийн албанаас 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр “Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулан” цахим уулзалтад;

- Захиргааны хэргийн танхимын тэргүүн Ч.Тунгалаг, Тамгын газрын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч С.Амардэлгэр, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга Д.Тулга нар Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/-ын Ардчилсан институт, хүний эрхийн албаны төлөөлөгч Рената Тардиолиг 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулан,

- Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Тамгын газрын дарга С.Амардэлгэр нар Азийн сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч Марк Кэйнигтэй 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдөр,

-Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Тамгын газрын дарга С.Амардэлгэр Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Н.Отгончимэг нар Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн "Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах" төслийн удирдагч Л.Заяа, төслийн ахлах мэргэжилтэн Б.Жавхлан нарыг 2021 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр,

- Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Тамгын газрын дарга С.Амардэлгэр, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга Д.Тулга, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Халиунаа нар ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны санхүүжилтээр олон улсад үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг Ханнс Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын шинэ тэргүүн, ноён Феликс Гленкийг 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдөр тус тус хүлээн авч уулзаж санал солилцов.

Шүүхийн даалгаврын хүрээнд:

Шүүхийн даалгавар буюу эрх зүйн туслалцааг хилийн чанадад илгээх болон хилийн чанадаас ирсэн хүсэлтийг Иргэний хэргийн хувьд хариуцах Дээд шатны байгууллага нь Улсын дээд шүүх бөгөөд гадаад улсад нийт 8 шүүхийн даалгавар илгээснээс БНХАУ-д 3, БНСУ-2, Япон улсад-1, Унгар улсад-1, Украин улсад-1, Тайванд-1 шүүхийн даалгавар тус тус илгээсэн байна.

Харин хилийн чанадаас нийт 11 буюу ХБНГУ-1, БНФУ-1, БНЧУ-1, БНСУ-7, ШХУ-1 шүүхийн даалгавар тус тус ирснийг харьяалах шүүхэд хүргүүлэн гүйцэтгүүлэх арга хэмжээг авч 9 даалгаврын хариуг буцаан илгээсэн байна.

Шүүхийн даалгавар буюу эрх зүйн туслалцааг хилийн чанадад илгээх болон хилийн чанадаас ирсэн 2014-2021 оны хооронд гадаад улсад хүргүүлсэн албан даалгаврын байдлыг хүснэгтээр харуулбал:

	Шүүхийн даалгавар хүргүүлсэн улс /тоо/	
2014	Бүгд найрамдах солонгос улс	6
2015	Бүгд найрамдах солонгос улс	4
	Бүгд найрамдах хятад ард улс	4
	Япон улс	1
2016	Бүгд найрамдах солонгос улс	14
	Бүгд найрамдах хятад ард улс	4
	Их Британи	1
	Холбооны бүгд найрамдах герман улс	1
2017	Беларусь	1
	Бүгд найрамдах солонгос улс	4
	Бүгд найрамдах хятад ард улс	3
	Казакстан	1
	Чех	1
	Болгар	1
	Польш	1
Украин	1	
2018	Бүгд найрамдах солонгос улс	18
	Бүгд найрамдах хятад ард улс	3
	Хонг Конг	1

	Болгар	2
	Итали	1
	Оросын холбооны улс	2
	Япон улс	1
	Их Британийн Брижинийн арлууд	1
	Америкийн нэгдсэн улс	1
2019	Бүгд найрамдах солонгос улс	8
	Бүгд найрамдах хятад ард улс	4
	Болгар	1
	Япон улс	1
	Холбооны бүгд найрамдах герман улс	1
2020	Бүгд найрамдах солонгос улс	1
	Япон улс	2
2021	Бүгд найрамдах солонгос улс	2
	Бүгд найрамдах хятад ард улс	3
	Япон улс	1
	Унгар улс	1
	Украйн улс	1
	Тайван	1

Харин гадаад улсаас ирүүлсэн шүүхийн даалгаврыг 2015-2021 оноор авч үзвэл:

Шүүхийн даалгавар ирүүлсэн улс /тоо/		
2015	Бүгд найрамдах солонгос улс	1
	Бүгд найрамдах хятад ард улс	1
	Украйн	1
	Австрали	1
2016	Бүгд найрамдах солонгос улс	1
	Америкийн нэгдсэн улс	1
	Австри	1
	Турк	1
2017	Бүгд найрамдах солонгос улс	1
	Чех улс	1

	Япон улс	1
	Холбооны бүгд найрамдах герман улс	2
2018	Бүгд найрамдах солонгос улс	7
2019	Бүгд найрамдах солонгос улс	10
	Болгар	2
	Оросын холбооны улс	1
2020	Бүгд найрамдах солонгос улс	1
	Чех улс	1
2021	Холбооны бүгд найрамдах герман улс	1
	Бүгд найрамдах солонгос улс	7
	Бүгд найрамдах франц	1
	Бүгд найрамдах чех улс	1
	Швейцарийн холбооны улс	1

Бусад:

Гадаад харилцааны асуудлаар хийх уулзалт, зөвлөгөөний бэлтгэлийг урьдчилан хангаж, удирдлагыг тухайн асуудлаарх шаардлагатай мэдээллээр ханган Ерөнхий шүүгч болон шүүгчдийг гадаадын зочид, төлөөлөгчидтэй уулзалт хийх ажлыг зохион байгуулан ажилласан байна.

Мөн Улсын дээд шүүхийн Тамгын газраас эрхлэн Ханнс–Зайделийн сангаас санхүүжүүлэн нийт иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шүүгч нарын ажлын хэрэгцээнд зориулан **“Иргэний хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай”** гарын авлага номын ажлын хэсэгт орж ажиллан, шүүгч нарт тараах ажлыг зохион байгууллаа.

Шүүхийн багц хуулийн төсөлтэй холбогдуулан Тамгын газрын даргад 1 тухайлсан сэдэв бүхий орчуулга гаран өгөв.

Шүүгч, ажилтан нарт зориулан дэлхий дахинд болж буй шүүх болон хуулийн цаг үеийн мэдээ, мэдээллийг орчуулан Гадаад улсуудын шүүхийн үйл ажиллагааны туршлага судлах талаар 35 гадаад мэдээ орчуулж хүргэв.

Бусад зохион байгуулалтын ажлын хүрээнд 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулагдсан Нийт шүүгчийн анхдугаар чуулган, Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан "Шүүх эрх мэдэл, хууль сахиулах

алба хаагчдын үндэсний чуулган"-д тус тус зохион байгуулалтын ажилд оролцсон байна.

Гадаад улс орны шүүхийн үйл ажиллагааны туршлага судалж, манай улс оронд нэвтрүүлж болох зүйлийг хэрэгжүүлэх талаар анхаарал хандуулан ажиллаж байна.


2.6. ШҮҮХИЙН ТӨСӨВ, САНХҮҮ, ДЭД БҮТЦИЙГ УДИРДАХ ЧИГЛЭЛЭЭР:

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар Улсын дээд шүүхийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц **5,2** тэрбум төгрөгөөр батлагдсан.

Батлагдсан төсвийн хүрээнд хяналтын шатны шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах, шүүгч ажилтнуудын ажиллах ая тухтай нөхцөл бүрдүүлэх, төсвийг хууль журмын дагуу зориулалтын дагуу зарцуулахад анхаарч ажиллаа.

2021 онд дэлхий нийтийг хамарсан ковид цар тахлын нөхцөл байдал үүссэнээс шалтгаалан улс орны нийгэм, эдийн засгийн хүндрэлтэй цаг хугацаанд батлагдсан төсвийг бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын Коронвируст халдвар /Ковид-19/- аас урьдчилан сэргийлэх төрийн тусгай хамгаалалт бүхий объектод баримтлах түр журамд заасны дагуу төсвийн сахилга баттай, үр ашигтай оновчтой хуваарилах зарчмыг баримтлан ажилласан.

2021 оны төсвийн зарцуулалтыг эдийн засгийн ангиллаар харуулбал: /сая. төгрөгөөр/



Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын дээд шүүхийн 2022 оны урсгал төсвийг **14,2** тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын

төсвийг **1,8** тэрбум төгрөг буюу нийт **16,0** тэрбум төгрөгөөр төлөвлөж УИХ, Сангийн яаманд хуульд заасан хугацаанд хүргүүлсэн бөгөөд “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем”, төсвийн төлөвлөлтийн Fiscal.B цахим системүүдэд орууллаа.

2022 оны төсвийн төслийг Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны хурлаар **11,9** тэрбум төгрөгөөр хянуулсан ба “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай” хуулиар Улсын дээд шүүх **8,5** тэрбум төгрөг, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн **1,1** тэрбум төгрөг нийт **9,6** тэрбум төгрөгийн урсгал зардал, мөн хөрөнгө оруулалтын **1,08** тэрбум төгрөг, бүгд **10,6** тэрбум төгрөгийн төсөв батлагдлаа.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд Улсын дээд шүүхийн дэргэд Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн ажиллана гэж заасны дагуу тус хүрээлэнгийн төсвийг тусад нь боловсруулж батлуулсан болно.

Төсвийн тухай хуульд заасан хугацаанд 2022 оны төсвийн санхүүжилтийн хуваарийг боловсруулан Сангийн яаманд хүргүүлж, цахим системд оруулсан болно.

Улсын дээд шүүхийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, нийгмийн даатгалын тайлан, хувь хүний орлогын албан татварын тайланг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУСтандартад нийцүүлэн гарган холбогдох газруудад хүргүүлсэн болно.

Санхүү, хангамж, үйлчилгээний хүрээнд 2021 онд хийсэн ажлуудаас тоймлон авч үзвэл:

2021 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг батлуулсан бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан “Улсын дээд шүүхийн тээврийн хэрэгслийн даатгалын үйлчилгээг үзүүлэгчийг сонгон шалгаруулах”, “Улсын дээд шүүхийн вэб сайтыг шинэчлэн сайжруулах”, “Шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах”, “Компьютерийн үйлдлийн систем, оффис программын лиценз худалдан авах” тендерүүдийг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу нээлттэй цахим хэлбэрээр зарлаж амжилттай шалгарууллаа.

“Улсын дээд шүүхийн тээврийн хэрэгслийн даатгалын үйлчилгээг үзүүлэгчийг сонгон шалгаруулах” тендерт “Хаан даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Ард даатгал” ХК нар оролцсоноос “Ард даатгал” ХК шалгарч гэрээ байгуулсан.

“Улсын дээд шүүхийн вэб сайтыг шинэчлэн сайжруулах” тендерт “Бодь Электроникс” ХХК, “Содонвишн” ХХК компаниуд оролцсоноос “Бодь Электроникс” ХХК шалгарснаар, шинэ цахим хуудас хийг ажлыг гүйцэтгэн хүлээлгэж өгсөн байна.

“Шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах” тендерт “Ард даатгал” ХК оролцож гэрээ байгууллаа.

“Компьютерийн үйлдлийн систем, оффис программын лиценз худалдан авах” тендерт “Женералтеч” ХХК, “Компьютер бизнэс сольюшинс” ХХКомпаниуд оролцсоноос “Женералтеч” ХХК шалгарч гэрээ байгуулсан болно.

Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журмын 7.1.3-т “шүүгч, ажилтныг шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах” гэж заасны дагуу батлагдсан төсвийн хүрээнд **51.2** сая төгрөгийн принтер, компьютер, дэлгэц, дуу хураагуур, сандал, сейф, агаар цэвэршүүлэгч, ноорог устгагч болон бусад хөрөнгийг худалдан авсан байна.

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор ариутгалын хаалга, мананцар үүсгэгч, цэвэрлэгээний болон ариутгалын бодис, нэг удаагийн хувцас хэрэгсэл, маск бээлий, гар ариутгагч, түргэвчилсэн оношлуур болон бүх шүүгч ажилтнуудад урьдчилан сэргийлэх амин дэм ариутгалын бодисын багц тараахад нийт **18,9** сая төгрөгийн зардал гаргажээ. Мөн 11 дүгээр сард халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор шүүгч ажилтнуудад өдөр бүр халуун чацаргана чанаж үйлчлэх ажлыг зохион байгуулсан болно.

“Халдваргүйжүүлэлт” ХХК-иар ажлын байранд 5 удаа иж бүрэн ариутгал хийлгэж **1,7** сая төгрөг зарцуулсан бөгөөд халдваргүйжүүлэлт хийлгэсний дараа болон сар бүр их цэвэрлэгээний ажлыг тогтмол хийж, өдөрт 2 удаа ариун цэврийн өрөө, шат хаалганы бариулыг ариугагч бодисоор арчиж цэвэрлэн, мананцар үүсгэж халдвар тархах аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг хийжээ.

Ковид-19 цар тахлын үед сувилагч шинээр авч их эмч, сувилагч 2 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Эмч сувилагч нар нь өдөрт дунджаар 15-20 хүнд тогтмол түргэвчилсэн шинжилгээ хийж халдвар илэрсэн үед үзлэг, эмчилгээ хийж, шаардлагатай тохиолдолд дараагийн шатны эмнэлэг болон гэрийн тусгаарлалтанд явуулж ажиллаа. Түргэвчилсэн тестийн шинжилгээг цусаар 48, шүлсээр 25, хамраар 296, нийт 369 хүнд хийсэн ба шинжилгээ хийлгэсэн хүмүүсээс нийт 63 хүнд халдвар илэрсэн байна.

Эмч сувилагч нар нь өдөрт 10-15 хүнд тогтмол үзлэг хийж, зүү төөнүүр, иллэг, бариа засал, бумба тавих, шарлага хийх, судас болон булчин тариа хийх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд нийт давхардсан тоогоор 2610 хүнд үзлэг эмчилгээ болон 10 хүнд боолт хийсэн байна.

Цар тахлын үед хяналтын шатны шүүн таслах ажиллагааны аюулгүй байдлыг хангаж болзошгүй эрсдлийг бууруулах зорилгоор онлайн хэлбэрээр шүүх хуралдааныг явуулах цахим хурлын лиценз худалдан авах зардалд 7,0 сая төгрөг зарцуулжээ.

Шүүгч ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах, ая тухтай байдлыг хангах зорилгоор дор дурдсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.

Үүнд:

- Улсын дээд шүүхийн А байрны 2 давхрын 207 зөвлөлдөх тасалгаа болон 208 хурлын заалны засвар хийж тохижуулсан;
- Б байрны 401 тоот 1 өрөөнд тусгаарлалт хийж 2 өрөө болгон зассан;
- Б байрны 404 тоот 1 өрөөнд тусгаарлалт хийж 2 өрөө болгон өөрчилсөн;
- Б байрны 1 давхрын шатанд хаалгатай хаалт хийсэн;
- Б байрны 1 давхрын хуучин өлгүүр байсан өрөөг архивын өрөө болгон тохижуулсан;
- А байрны 2 талын шатны ханыг шинээр эмульсдсэн;
- Б байрны гадна талын бохирын шугам сольсон;
- Улсын дээд шүүхийн А байрны гадна талын шатны хагарсан чулууг сольж шинэчилсэн;
- Автомашинуудын гражын дээврийн хар цаас сольсон;
- Улсын дээд шүүхийн Б байрны 1 давхрын шалны цөмөрсөн хэсгийг сольж зассан;
- Б байрны 4 давхар болон 1 давхарт ус цэвэршүүлэгч шинээр суурилуулсан;
- Дулааны шугамын үзелийн өрөөний труба сольж шинэчилсэн;
- А байрны 101 тоот үйлчлэгч нарын өрөөнд иж бүрэн засвар хийсэн;
- Дулааны өгөх буцах шугам сольсон;
- Дулааны тоолуур авч суурилуулсан;
- Б байрны 1 давхрын хуучин бичиг хэрэг болон мэдээлэл лавлагааны 1 өрөөг тусгаарлан 2 өрөө болгон засаж тохижуулсан;

- А байрны гол модон хаалга хуучирч муудан завсар гарч, дулаан алдагдаж байсныг сольж шинээр хийлгэсэн;
- Гадна талын метал хаалгыг шинэчлэн сольсон;
- Бүх автомашинуудыг үзлэг оношлогоонд оруулж, төлөвлөгөөт засвар үйлчилгээг хийлгэсэн;
- Улсын дээд шүүхийн А, Б байрны өрөөний хаалганд лацны суурь суурилуулан бүх шүүгч ажилчдад лац хүлээлгэн өгсөн;
- Шүүх хуралдааны заал болон зөвлөлдөх тасалгаануудад агаар шүүгч болон самбар байршуулсан.

Тамгын газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/36 дугаар тушаалаар батлагдсан тооллогын комисс ажиллаж жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийж дуусгалаа. Тооллогоор үндсэн болон эргэлтийн хөрөнгөнд бүртгэлтэй бүх хөрөнгийг шүүгч ажилтнуудын эзэмшиж байгаа хөрөнгийн карттай тулган баталгаажуулж, элэгдлээ нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх, ашиглах боломжгүй болсон хөрөнгийг актлах саналыг боловсрууллаа.

Үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд бүртгэлтэй бүх хөрөнгийг нэр төрөл маркаар нь тулган зургийн цомог үүсгэж, шүүгч ажилтан тус бүрээр программд бүртгэн үндсэн хөрөнгө бараа материалын цахим бүртгэлийн ажлыг шинэ түвшинд гаргалаа.

Шүүгч ажилтнуудад давхардсан тоогоор 101 хүнд **19,9** сая төгрөгийн буцалтгүй тусламжийг холбогдох тушаал шийдвэрийн дагуу олгосон байна.

Хяналтын шатны шүүн таслах ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах зорилгоор шүүгчийн туслахуудын өрөөний утасны сард ярих ярианы хязгаарыг 2 дахин нэмэгдүүлсэн болно.

Төрийн байгууллагууд төрийн албаны цалингийн нэгдсэн системд шилжиж байгаатай холбоотойгоор цалингийн программыг өөрийн байгууллагын онцлогт тохируулан загвар үүсгэж олгох ажлыг зохион байгууллаа.

Монгол Улсын Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд “Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 20.9-д заасан ажлын хэсэг Нийт шүүгчийн чуулганыг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор зохион байгуулж, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүнийг сонгоно. Нийт шүүгчийн чуулганыг зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг

Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл хамтран хариуцна.” гэж заасны дагуу нийт шүүгчдийн чуулганы ажлыг зохион байгуулсан бөгөөд холбогдох зардлыг гаргалаа.

Шүүхийн сургалт судалгаа, мэдээллийн хүрээлэн 2022 оны 1 дүгээр сараас ажиллаж эхлэхтэй холбоотойгоор бэлтгэл ажлын хүрээнд 14 хүн шинээр авч ажиллуулсан бөгөөд цалингийн зардалд **58,8** сая төгрөгийг төсвийн хэмнэлтээс зохих эдийн засгийн ангиллын дагуу зарцуулсан байна.

Эдгээр ажилтнуудын хэвийн ажиллах орчинг бүрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангажээ.

Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2021 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тогтоолын дагуу шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын үндсэн цалингийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлэх гэж заасны дагуу цалингийн зардлын тооцоог хийж холбогдох газруудад хүргүүлсэн болно.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд www.shilendans.gov.mn болон Улсын Дээд шүүхийн сайт дахь Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, бүтэн жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш хэмжээтэй зардал зэрэг холбогдох шаардлагатай мэдээ, мэдээллүүдийг цаг тухай бүрт нь хуулийн хугацаанд оруулах, шүүхийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг tender.gov.mn сайт дээр байршуулах зэргээс гадна холбогдох бусад тайлан, мэдээг гаргаж Сангийн яам болон бусад газруудад хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллалаа.

Монгол Улсад коронавирус /COVID-19/-ын халдвар бүртгэгдэж, улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан, уг халдварын тархалтаас урьдчилан сэргийлж, “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хяналтын шатны шүүхийн ажиллах түр журам”-ын хэрэгжилтийг ханган ажилласан байна.



**ГУРАВ. ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН**

ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2021 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

3.1. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс дараах 4 сургалтыг зохион байгуулав:

- Шүүгч-багш бэлтгэх сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн 3 өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан ба хяналтын шатны 19 шүүгч хамрагдсан байна.
- Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүгчдийн 2021 оны сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 09, 10-ны өдөр 36 шүүгч, 2021 оны 12 дугаар сарын 13, 14-ний өдөр 44 шүүгчийг хоёр ээлжээр хамруулан танхимаар зохион байгуулав.
- Нийслэлийн Иргэний хэргийн шүүхийн шүүгчдийн 2021 оны хууль хэрэглээний сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 22, 23 болон 27, 28-ны өдрүүдэд 2 ээлжээр 87 шүүгчийг (тахимаар-79, цахимаар-8) хамруулан танхимаар зохион байгуулав.
- “Үндсэн хуулийн эрх зүй: Хүний эрх”, “Шүүгчийн ёс зүй”, “Эрүүгийн эрх зүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй: Хөөн хэлэлцэх хугацаа, түүнийг тоолох журам” хөтөлбөрийн сургалтыг Азийн сангийн дэмжлэгтэйгээр сургалтын тусгай платформ болох “Skillup.mn” цахим системд 2021 оны шүүгчийн 3 төрлийн сургалтыг 2021.12.20-2022.01.20-ний хооронд үзэхээр, мэргэжлийн студиэр сургалтын видеог урьдчилан бэлтгүүлж байршуулав.
- 2021 оны шүүгчийн сургалттай холбоотой үнэлгээг сургалтад хамрагдсан шүүгчдээр хийлгэн, үр дүнг нэгтгэв.

2. Сургалтын хөтөлбөрийн хорооны хурлыг 2021 оны 9 дүгээр сарын 13, 2021 оны 11 дүгээр сарын 1-ний өдрүүдэд 2 удаа амжилттай зохион байгуулж 2021 онд зохион байгуулах шүүгчийн сургалтын хөтөлбөрийг эцэслэн шийдвэрлэж батлуулсан.

3. 2021, 2022 оны шүүхийн сургалтын санал болон эрүүгийн хэргийн бүх шатны шүүгчдийн мэргэшсэн болон мэргэших чиглэлээр нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх зорилгоор анхан шатны 93, давж заалдах шатны 37 шүүгчээс мэдээлэл авч сан бүрдүүлэв.

3.2. Шүүх, шүүгчдийг судалгаа, лавлагаа, мэдээллээр хангах чиг үүргийнхээ дагуу Шүүхийн судалгааны төвөөс дараах 14 судалгаа, лавлагаа, тоймыг гүйцэтгэн захиалагчид хүргүүлэв:

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3, 106.5 дахь хэсгийн хэрэглээний судалгаа;
- Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийг сэлгэн ажиллуулах, Гаалийн тухай хуульд заасан гаалийн албан хаагчийг сэлгэн ажиллуулахтай холбоотой шүүхийн шийдвэрийн лавлагаа;
- Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын данстай холбоотой шүүхийн шийдвэрийн лавлагаа;
- “Эрүүгийн хэргийн улмаас учирсан хохирол гэх хүү, нэмэгдүүлсэн хүүг олох байсан орлогод тооцон хохирол нэхэмжилж буй маргаан” сэдэвт судалгаа;
- Монгол Улсын Эрүүгийн шүүн таслах ажиллагааны талаарх хөгжлийн чиг хандлага, тулгамдаж буй асуудлууд тойм;
- Өршөөл үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн судалгаа;
- “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа: тулгамдаж буй асуудал” сэдэвт судалгаа;
- “Хувийн эрх зүйн шинэтгэл ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт судалгаа;
- “Монгол Улсын шүүхийн шинэчлэл ба Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга” тойм мэдээлэл;
- Шүүхийн шийдвэрийн түүвэр;
- Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа (2019-2021 оны тогтоолын түүвэр);
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн хэрэглээний тухай судалгаа;
- Иргэний хэргийн зарим маргааны харьяаллыг захиргааны хэргийн харьяаллаас ялгах тухай судалгаа;
- Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдсэн хэргийн тоон судалгаа, тоон мэдээлэл.

3.3. Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, Ханнс Зайдел сан, Азийн сан зэрэг шүүх эрх мэдлийн хүрээнд хамтран ажилладаг олон улсын байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт хийж, Азийн сантай 2021 оны шүүгчийн сургалтын видео хичээл бэлтгэхэд хамтран ажиллав.

6. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, тус хүрээлэнгийн Хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвийн дарга В.Энхтамир нартай уулзаж, эрх зүйн судалгаа, эрдэм шинжилгээний чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцов.

7. Улсын дээд шүүхээс орон нутгийн болон нийслэлийн шүүхүүдийн үйл ажиллагаатай танилцах, шүүгч нартай уулзах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Хүрээлэнгийн удирдлага оролцон, байгууллагынхаа үйл ажиллагааны танилцуулга хийв.

8. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах, мэдээлэх зорилгоор танилцуулга бэлтгэн, олон нийтийн цахим сүлжээг ашиглан хүрээлэнгийн цаг үеийн мэдээ, мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна.

9. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, аргачлалыг боловсруулан мөрдүүлж ажиллаж байна.

10. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн ажилчдыг Архив, албан хэрэг хөтлөлт, Шүүгчийн сургалтын тусгай платформыг удирдах, хэрэглэх талаар, Засгийн газрын худалдан авах ажиллагааны зэрэг сургалтуудад хамруулан хүний нөөцийг чадавхжуулан ажиллаж байна.